

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8-46

1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	8-27
2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	27-29
3.Төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайланг сонсох	29-42
4.“Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	42-46

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 14-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 17 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаатар, Б.Чойжилсүрэн;

Тасалсан: Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Ж.Батсуурь, С.Одонтуяа.

Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, дэд сайд С.Зулпхар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Төрийн захиргааны удирдлагын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Тэгшжаргал, Ц.Лхагвагэрэл, Ц.Отгонбаатар нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Д.Тогтохсүрэн, Ж.Батжаргал, Ш.Раднаасэд, Г.Тэмүүлэн нарын тавьсан Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 7
Бүгд: 11
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслүүдийн талаар санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, дэд сайд С.Зулпхар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дарга С.Тунгалагтамир, Төрийн захиргааны удирдлагын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Ц.Лхагвагэрэл, Ц.Отгонбаатар нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайланг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Мэдээллийн технологийн төвийн захирал Д.Энхтуяа, Дотоод аудит, Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Баярмаа, менежер Б.Баттуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Ц.Лхагвагэрэл, Ц.Отгонбаатар нар байлцав.

Төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаар Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайланг сонслоо.

Уг асуудлыг 17 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Мэдээллийн технологийн төвийн захирал Д.Энхтуяа, Дотоод аудит, Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Баярмаа, менежер Б.Баттуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Ц.Лхагвагэрэл, Ц.Отгонбаатар нар байлцав.

Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх сэдвийн талаар Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-очир, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 7
Бүгд: 11
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 34 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 17 цаг 51 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр, Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 15 цаг 17 минут.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн байна. Та бүхэнд ирцийг танилцуулъя.

Хавдисламын Баделхан гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Та бүхэнд байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. Засгийн газар 2023 оны 06 сарын 08-ны өдөр өргөн мэдүүлсэн төсөл байна. Хэлэлцэх эсэх асуудал байгаа.

2 дахь нь, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-25 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг байгаа.

3-д, Төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайлан.

4-д, Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэх. Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх сэдэв батлах тухай гэсэн ийм 4 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

1 дүгээр асуудал. **Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хамт өргөн мэдүүлсэн 7 хууль, 2 Улсын Их Хурлын тогтоол байгаа. Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж эхэлье.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Сангийн сайд Болдын Жавхлан сайд танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт хуулийн 7 төсөл, Улсын Их Хурлын тогтоолын 2 төслийг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийн талаар товч дурдвал:

1.Төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэг хуулиар зохицуулах, төрийн албан хаагчийн тоог үндэсний ажиллах хүчний тоотой уялдуулан тогтоох, төрийн албан хаагчийн үндсэн цалин ба нэмэгдлийн харьцааг оновчтой болгох зэрэг зохицуулалтыг Төрийн албаны

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн албанд ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хуульд заасан ажилласан жилийн тусгай шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд бууруулан тооцох зохицуулалтыг Төрийн албаны тухай нэмэлт оруулах хуулийн төсөлд тусгалаа. Энэхүү өөрчлөлттэй уялдуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн агентлагийн даргаар хуульд заасан ажилласан жилийн тусгай шаардлагыг хангасан хүнийг томилж болох, энэ тохиолдолд агентлагийн дэд даргатай байх зохицуулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд тусгасан болно.

2.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар төрийн байгууллагуудаас ирүүлж байгаа санал, хүсэлтийг харгалзан хэмнэлтийн зарим зохицуулалтыг өөрчлөх санал боловсрууллаа. Тухайлбал, хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаа болон төрийн байгууллагын үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах үүднээс эдгээр байгууллагууд автомашинтай байхаар хуулийн төсөлд тусгав. Мөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж дууссан байвал зохих хугацааг хойшлуулах өөрчлөлтийн хуулийн төсөлд тусгасан болно.

Засгийн газраас хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлыг онцгой анхаарч үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан агентлагийн бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Үүнтэй холбогдуулан залуучуудын хөгжлийг дэмжих төрийн чиг үүргийг цаашид иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр тооцож,

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

4.Төр хувийн хэвилийн түншлэлийн шинэчлэлийг хөрөнгө оруулагч нарт сурталчлан таниулах, түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн судалгаа хийх, хүний нөөцийн чадавх бэхжүүлэхэд тодорхой хугацаа шаардлагатай байгаа.

Мөн шинэ хуулийн дагуу хууль хэрэгжиж эхэлмэгц байгуулагдсан байх ёстой, төр, хувийн хэвилийн түншлэлийн төв зэрэг нэмж байгуулагдах ёстой Засгийн газрын бүтцийн нэгжүүдийг бас байгуулах ажил тодорхой хэмжээнд хойшлогдоод бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй зэрэг шаардлагууд байгаа учраас Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийн үйлчлэлийг хагас жилээр хойшлуулах, төрийн өмчийн эрдэм шинжилгээ судалгааны байгууллагууд бага зардлаар өндөр бүтээмжит бүхий технологи, шинэ бүтээл, нэвтрүүлэхийг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

Түүнчлэн нам, орбитын хиймэл дагуулын сүлжээ ашиглан иргэдэд өндөр хурдны интернэтийн үйлчилгээг газар зүйн байрлал харгалзахгүй үзүүлэхтэй холбогдуулан Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрд олгох 2023 оны 1-6 дугаар саруудад хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдаагүй хүүхдэд уг хугацаанд ноогдох мөнгөн тэтгэмжийг нөхөн олгох зорилгоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж хэлэлцүүлж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2023 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлаа.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайдад баярлалаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Сангийн сайд Болдын Жавхлан, Хүрэлбаатарын Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сархадын Зулхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Байгалмаагийн Одонтуяа Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Амарсайханы Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Балсангийн Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Сандагийн Тунгалагтамир Хөдөлмөр, нийгмийн

хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Дугаржавын Ренчиндорж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга гэсэн байна.

Хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Батжаргал гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Дагасан хууль дээр Төрийн хэмнэлтийн хууль дээр 5 заалт орж ирж байна. Нөгөө хэмнэлтийн хуулиар төр өөрөө бүсээ чангалж, хэмнэлтийг бий болгоно гээд байсан. Одоо төсвийн хүндрэлийг давсан гэж үзэж, нөгөө тавьсан хязгаарлалтуудаа суллаж байгаа юм уу? Зарим байгууллагуудыг дүрэмт хувцас өмсөж болно гэж нээж өгч байгаа юм байна. Зарим байгууллагуудыг унаа, машин унаж болно гэж нээж өгч байгаа юм байна. Мөн хэмнэлт юмнуудыг зарцуулах эрхийг нь өгч байгаа юм байна гэж ингэж ойлгож байна.

Тийм учраас яг нөгөө энэ хууль дээр зүйл заалтуудаар ороод ирсэн учраас яг ямар, ямар бололцоо боломжуудыг Төрийн хэмнэлтийн дагасан хууль дээр оруулж өгч байгаа вэ гэдгийг 1-д жоохон дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч.

2-т, Жавхаа сайд аа, энэ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр тендерийн хууль л даа. Тэгээд тендерийн хууль чинь нэмэлт, өөрчлөлт хийгдээд маргааш эцэслэн батлагдах гэж байна. Сангийн яам өөрөө өргөн барьсан. Тэгээд энэ 3.15 дахь заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж ирж байгаа юм. Тэгээд төсвийн тодотголыг дагуулж Тендерийн хуульд тэгээд тэр дундаа бүр ингээд нөгөө зохицуулахгүй харилцаанд энэ харилцааг оруулж ирж байна л даа. Үгүй ээ, дагасан хуулийн, Тендерийн хуулийн 3.15-ыг яриад байна шүү дээ. Та түрүүн бас уншиж байна лээ. Тэгээд 1 талаар энэ Засгийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

газар чинь өөрөө төрийн байгууллагууд, хувийн хэвшлийнхэнтэй өрсөлдөхгүй ээ гэдэг ийм зарчим яриад байгаа юм. Бодлого яриад байгаа юм. Тендерийн хууль дээр өөрчлөлт оруулж байна шүү дээ. Та өөрөө дагасан 7 хуулийн чинь нэг нь энэ тендерийн хууль шүү дээ. Тэгээд та өөрөө саяхан уншиж байх шиг байсан. Тэгээд энэ төрийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагуудын энэ тендерт орох нөхцөлийг л бүрдүүлж энэ эрдэм шинжилгээний байгууллагууд л тендергүйгээр иүүд худалдан авалт л хийх нь л дээ. Тэгээд ингээд энэ Тендерийн хуулийг ингээд энд тэндээс нь салбар, салбараар нь ингээд орж ирээд ингээд 1, 1 ингээд энэ хуулиар энэ харилцааг зохицуулахгүй ээ гээд ингээд ирэхээр чинь ер нь энэ Тендерийн хуулийн чинь мөн чанар, утга агуулга ер нь алдагдлаа шүү дээ.

Уг нь бол энэ 12 сарын 01-нээс маргааш эцэслэн батлагдах энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт 12 сарын 01-нээс хэрэгжиж эхэлнэ. Үүгээр цаашидаа ер нь төрийн байгууллагуудыг тендерт оролцох нөхцөл бололцоог нь хангаж өгч байгаа шүү дээ, ер нь бол. Яагаад гэхээр өнөөдөр төсвийн байгууллагууд арилжааны банк дээр дансгүй байгаа. Тийм учраас барьцаа хөрөнгө гаргаж чадахгүй байгаа. Үүгээрээ болоод тендерт оролцож чадахгүй байгаа. Энэ нэмэлт, өөрчлөлтөөр 12 сарын 01-нээс хэрэгжээд эхлэхээр нөгөө Тэмүүлэн гишүүн нарын өргөн барьсан хуулиар нийгмийн даатгалын байгууллагууд барьцаа гаргаж болно гэдэг тэр хуулиараа ингээд нээлттэй болж ирж байгаа байхгүй юу. Энэ хуулийн өөрчлөлтийг хийсэн, хийгээгүй. Тэгэхээр би үүнийг харах нь ээ, өнөөдрөөс авхуулаад 12 сарын 01 хүртэлх хугацаанд энэ нэг он дуустал хугацаа нь 3, 4 сарын хугацаанд энэ эрдэм шинжилгээний байгууллагууд нэг тендерт оролцож, тендер авах гээд байгаа юм болов уу л гэж ингэж хараад байх юм. Тэгээд энэ энэ 3.15-ын заалтыг ямар утга агуулгатай

ингэж нээж өгч байгаа юм бэ? Үүнийг тодруулж өгөөч?

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя, Жавхлан сайд. Жавхлан сайд.

Б.Жавхлан: 1 дүгээрт, хэмнэлтийн хуультай холбоотой асуулт асуулаа. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ хэмнэлтийн хуулиасаа ухраад ч юм уу зарлагуудыг нь нээж өгч байгаа талаасаа биш шүү. Төрийн хэмнэлтийн хууль бол маш сайн хууль гарсан. Энэ үе үеийн л Сангийн яам, Сангийн сайд нарын зовлонг бас хууль тогтоох байгууллага их сайн дэмжиж ойлгож, энэ хуулийг баталсан. Өнгөрсөн жилийн хугацаанд сайн ч үр дүнгээ өглөө. Цаашидаа ч энэ хууль ер нь урт хугацаанд оршин тогтноно гэж бодож байгаа.

Энэ удаа харин суллаж байгаа зүйлүүд маань төсвийн зардал гэхээсээ илүү яг тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хориг саад болоод байгаа, тасалдахад хүрэхэд ийм эрсдэлүүд учирч байгаа учраас зарим нэг заалтууд дээр нь ийм өөрчлөлт оруулж байгаа. Тухайлбал, тэр номын сан байгаа юм. Номын санг уг нь энэ хэмнэлтийн хууль дээр үндсэн үйл ажиллагаанд нь саад болохгүй бол гэдэг ийм заалт байгаа юм. Тэгсээр байтал номын сангууд маань энэ заалтыг бариад ном, хэвлэл гэдэг заалт руу яваад орчхож байгаа учраас номын сангийнхаа номын баяжуулалтыг жишээ нь хийж чадахгүй болчихоод байгаа юм. Түүнийг нь бүр яг тодруулж оруулж байгаа, номын санд гээд.

Хүүхэд хамгааллын байгууллагууд дээр жишээ нь автомашингүй болчихоор бас үйл ажиллагаа нь тасалдах, мөн өөр тусгай чиглэлийн ийм автомашинуудыг хэрэглэдэг шуурхай албатууд дээр мөн бас яг өөрсдийн хэрэгцээний автомашиныг нь тусгай хэрэглэл зориулалтад нь хангахгүй бол бас үйл ажиллагаа нь саатах ийм эрсдэл гарч

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байгаа учраас ингээж зохицуулалт хийсэн байгаа.

Тэр 5 заалт бүрийг ажлын хэсгээс нэг бүрчлэн уншаад танилцуулчхаарай.

2 дугаарт, тэр Тендерийн хууль дээр яах аргагүй тэр өөрчлөлт орсон. Энэ бид салбар салбарын нэлээн олон уулзалтуудыг энэ төсвийн тодотгол хийх үеэр өмнө нь ч мөн амжилттай хийсэн. Тэндээс гарч ирсэн олон саналуудаас бид нар зүгээр энэ нь авч болох юм, байж болох юм гэдэг байдлаар орж ирж байгаа юм. Тэр нь ялангуяа цалин хөлс багатай, нэмэгдэл багатай гэдэг олон жил бас ингээд цалингийн нэмэгдэл тусгагдаагүй гэсэн мөртөө үндсэн үйл ажиллагаанаасаа гадуур хуульд харшлахгүйгээр зөвлөх үйлчилгээ хийгээд нэмэлт орлого олоод, байгууллагаа санхүүжүүлээд, төрийн албан хаагч нарынхаа нийгмийн асуудлуудыг ч мөн шийдээд явах ийм боломж байгаа учраас тэр боломжийг нь л нээж өгч байгаа асуудал байгаа. Түүнээс биш тэр төрийн худалдан авах ажиллагааны урдуур нь ороод л, шууд тэнд давуу тал үүсээд л тэр тендерт нь ял л орох асуудал биш. Зүгээр энэ худалдан авах ажиллагаанд нь оролцогч байж болох юм гэдэг тэр талаас нь орж байгаа.

Даатгалын харилцаагаар зохицуулна гэх юм бол бас өрөөсгөл л дөө. Энэ төрийн байгууллагууд чинь өөрсдөө тэгж даатгалтай шууд харилцаад төрийн байгууллагаараа шууд даатгалын хамрагдаад, түүн дээр нь төсвөөр баталгаа гаргаж өгөх юм бол бүр зохицуулалт байхгүй ийм хоцорчихно. Тийм учраас энэ зохицуулалтыг нь дэмжиж өгөөч ээ л гэж хэлье.

Г.Тэмүүлэн: Нэмэлт тайлбарыг 3 номер Санжаадорж.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж Сандаг-Очир гишүүний асуултад хариулья. Төрийн хэмнэлтийн

тухай хууль дээр үндсэндээ 5 багц асуудлыг оруулж ирж байгаа.

Эхний хэсэг нь тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудал. Тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудал дээр аймаг, орон нутагт багийн дарга нар ихэвчлэн мотоцикл болон хувийн тээврийн хэрэгслээрээ ажил, албан үүргээ гүйцэтгэж байгаа. Харамсалтай нь энэ хуулиар нөгөө хориглосон заалтад орчихлоор шатахууны зардал тэр хүмүүс дээр тавьж чадахгүй болчихоод байгаа. Нөгөө талдаа бас нэмж тээврийн хэрэгсэл авч болохгүй болчихоод байгаа.

Мөн тээврийн хэрэгсэлд хүүхэд хамгааллын байгууллагуудыг тусгайлан оруулж өгөхгүй бол хүүхэд хамгааллын автомашин маань тусгай хэрэгслээр тоноглогчихсон, хүүхдэд зориулсан сандал, хэрэглэлтэй ийм машин байгаад байдаг. Энэ машиныг оруулж ирэхгүй бол болохгүй байна гэдэг ийм заалт оруулж ирж байгаа.

2 дахь нь, дүрэмт хувцастай холбоотой асуудал байгаа. Дүрэмт хувцас дээр зохицуулалт нь одоогийн хууль дээр яаж орсон байна гэхээр төрийн байгууллагуудын дүрэмт хувцсыг нэг талдаа зөвшөөрсөн заалтуудыг нь оруулчихаар, нөгөө талдаа хөдөлмөр хамгааллын хэрэгслүүдийг хамтад нь зарим хэсгийг нь зөвшөөрснөөр оруулж ирчхээд байгаа юм. Тэгэхээр бид нар хөдөлмөр хамгааллын хэрэгслүүдийг нь тусад нь гаргаж Төрийн хяналтын хуульд хамаарахгүй байхаар оруулж ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл хөдөлмөр хамгааллын хэрэгсэлтэй холбоотой каск, малгай, бээлий гэх мэт ийм хэрэгслүүдийг дүрэмт хувцас гэдэг ангилалд оруулах шаардлагагүй. Тусдаа бүр бие даасан хууль байгаа учраас энэ хуулийнхаа хүрээнд шийдээд явах нь зөв байна гэж бодож байна.

3 дахь асуудал нь үндсэн үйл ажиллагаа нь жишээ нь, номын сангийн үйл ажиллагаа байлаа гэхэд ном худалдан

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

авах ажиллагаа маань хэмнэлтийн хуульд ном хэвлэл гэдгээр орж ирчхээд байгаа. Тэгэхээр үндсэн үйл ажиллагаа номын сангийн асуудал байгаа бол яг номын санд ном, хэвлэлийн асуудал хамаарахгүй ээ гэдэг ийм зүйл оруулж ирж байгаа.

Дараачийн нэг асуудал нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн бол албан тушаалтанд шууд хариуцлага тооцож, ажлаас халах асуудал орж ирчхээд байгаа. Энэ асуудал бол ТАЗ-өөс болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ асуудал нь өөрөө төрийн албаны том малгай хуультайгаа зөрчилдөх асуудал болоод байна. Төрийн албаны тухай хуулиар бол шат дараалсан тэр зөрчил дээр нь арга хэмжээ аваад халах хүртэл шийтгэл явдаг. Хэрвээ энэ хэмнэлтийн хуулийг зөрчсөн асуудал маань өөрөө эрүүгийн шинжтэй ч юм уу, ашиглангийн шинжтэй байх юм бол эрүүгийн хариуцлагын тусдаа хуулиар явна гэдэг энэ асуудал яригдаж байгаа учраас Төрийн албаны тухай хуулиа дагаж мөрдөх нь зөв байна гэдэг асуудал орж ирж байгаа юм.

5 дахь өөрчлөлт нь хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлыг 05 дугаар сарын 31-ний дотор зохион байгуулаагүй бол үүнийг өөрөө хэмнэлтэд тооцоод бууруулахаар ийм зохицуулалт байгаагүй бол энэ мөрдөж эхлэх хугацааг нь бэлтгэл ажлыг хангах зорилгоор хойшлуулах ийм үндсэн 5 өөрчлөлт Төрийн хэмнэлтийн тухай хууль дээр орж ирж байгаа. Ямар нэгэн байдлаар Төрийн хэмнэлтийн хуулийн үндсэн зарчмаасаа ухарсан эсвэл сулласан гэж үзэж болохооргүй. Энэ заалтууд илүү ойлгомжтой тодорхой болгож байгаа гэдэг агуулгаар энэ заалтуудыг оруулж ирсэн гэж Засгийн газрын хувьд үзээд явж байгаа даа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Хариултууд гоё байлаа. Сайхан зөөлрүүлж хариулж байна. Ерөнхийдөө хуучин байсан юмнуудыг нь хаачаад, амьдралд нийцэхгүй болохоор нь буцаагаад л нээж өгч байгаа л асуудал шүү дээ. Түүнээс нэг их улам гоё тодорхой болгож байгаа юм ерөөсөө байхгүй гэдгийг мэдэж байгаа.

Аудитын байгууллагаас хэмнэлтийн хууль хэрэгжээд бүтэн жил хэрэгжсэн. Хэмнэлтийн хуультай холбоотойгоор аудитын дүгнэлт, акт, зөрчил ер нь яаж тавигдсан бэ? Тухайлбал, үйлдвэрийн газрууд дээр ажилтнуудаа сургасан сургалтыг сургалт хийж болохгүй ээ, зардал гаргасан байна гээд аудит акт тавьсан ийм мэдээллүүд байна. Тэгвэл үүгээр яах ёстой юм, ажилтнуудаа сургахгүй байх ёстой юм уу, мэргэжил боловсролыг нь дээшлүүлэхгүй байх ёстой юм уу, энэ чинь амьдрал дээр хэрэгжихгүй байгаа юм биш үү гэх мэтчилэн. Тийм учраас энэ акт тавигдсан зөрчил дутагдлууд юу гарсан бэ? Энэ ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Асуултад хариулах уу? Сангийн яам. Үгүй ээ яах вэ, аудитаас та бүхэнд ямар нэг зөрчил ч гэдэг юм уу, илрүүлсэн гаргасан юунууд юу байна гээд асуулт тавьж байх шиг байна. Хэмнэлтийн хуультай холбогдуулж. Холбогдох албан тушаалтан байна уу тайлбар өгөх. Тэгвэл холбогдох албан тушаалтан орж ирэх хүртэл түр. Угаасаа сүүлд нь аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан байгаа. Түүн дээр ч гэсэн нэмж тодруулж асууж болох байх, тийм ээ. Тэгье.

Тэгвэл Тогтохсүрэн гишүүн асуултаа асууя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Төсвийн тодотголыг дагаж 7 хуулийн төсөлд өөрчлөлт оруулах, 2 тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах хууль тогтоолын төслийг Засгийн газраас өргөн барьсан байна. Төсвийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

тодотголын хувьд бүрэн дэмжиж байгаа.

Дагасан хуультай холбогдуулж, би нэг 2 зүйлийг тодруулъя гэж бодож байгаа юм.

1 дүгээрт нь, Төрийн албаны хуульд орж байгаа өөрчлөлт. Энд энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой заалт байгаа юм. Мэдээж үүний цаана хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйл ажиллагааг дэмжих, даргыг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдээсээ байх, дэд дарга нь байх гээд ийм асуудал байгаа юм. Үүнийг дэмжээд байгаа юм. Гэхдээ нэг зүйл байгаа юм. Нэг агентлагаас болоод Төрийн албаны хуульд ингэж өөрчлөлт оруулаад, төрийн албан хаагчдад тавьж байгаа төрийн захиргааны удирдах албан тушаалтанд тавьж байгаа шалгууруудыг багасгачхаж байгаа юм. Жишээ нь, 23 дугаар зүйл дээр өөрчлөлт орчхож байгаа юм. Тэгэхээр цаашидаа юу гэдэг юм, нэг хөгжлийн нэг групптэй хүн л шаардлага нь бага болчих гээд болчихно шүү дээ, энэ чинь. Тийм. Нэг групптэй юм уу нэг юм тогтоолгосон, тийм хүн байвал тэгээд л төрийн албанд нөгөө шаардлага шалгуургүй явдаг болчих гээд байгаа байхгүй юу. Өөр албанд, өөр албанд, зөвхөн тэр нөгөө Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ агентлагт биш өөр албанд бас тийм болчхож байгаа байхгүй юу. Яагаад гэхээр 23 дугаар зүйлийг өөрчилжхөж байгаа байхгүй юу. Тэгэхээр би Засгийн газраас юу гэж асуух гээд байна вэ гэхээр энэ Засгийн газраас байгаа энэ Хууль зүйн яам, Хэрэг эрхлэхийн эд нараас. Юу гэж асуух гэж байгаа юм гэхээр заавал Төрийн албаны хуулийн 23 дугаар зүйлийг хөндөхгүйгээр энэ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн агентлагийн дарга, дэд даргыг томилоод явчих боломж байхгүй байгаа юм уу? Нэг агентлагаас болоод хуульд өөрчлөлт орохоороо цаашидаа энэ хуулийн шаардлага өөрөө буурчхаж байгаа юм. Бусад төрийн албан хаагчид, энэ чинь төрийн албан хаагчийн хамгийн гол нь

нөгөө өрсөлдөөнөөр явдаг, өрсөлдөөнөөр явдаг. Энэ Төрийн албаны хуулийн 23, 24 дүгээр зүйлээ биелүүлэх гэж өөрсдөө 16 жил зүтгэдэг байхгүй юу. Гэтэл нэг нөхөр шаардлага багатай ороод ирчих гээд ингээд нөгөө бусад албан хаагчдад өрсөлдөөнийг хааж байгаа нэг ийм юм харагдах гээд байгаа юм. Тийм учраас энэ талаас нь Засгийн газар харсан юм болов уу. Үүнийг заавал хуульд өөрчлөлт оруулахгүйгээр шийдчих боломж нэг дүгээрт байхгүй юм уу гэж асуух гэж байгаа юм.

2 дугаарт, Төрийн хэмнэлтийн тухай хууль дээр бас тодорхой хэмжээнд сулруулж байна. Энэ зөв өө. Төрийн хэмнэлтийн тухай хууль ялангуяа анхан шатанд бас тодорхой хэмжээнд ажил явуулахад хүндрэл учруулаад байгаа юм. 2022 онд л жишээлбэл энэ хууль хэрэгжсэний дараа энэ аймаг, сум тэгээд төсвийн шууд захирагч нарын хувьд нэлээд хэмжээний акт, шаардлага тавигдсан байна лээ, аудитын байгууллагаас. Тийм. Тийм учраас энд төсвийн шууд захирагч нарт ингэж бололцоо олгох нь би бол зүйтэй гэж бодож байгаа юм.

Харин дээр нь нэмэгдээд тэр унаа эд нар нээж өгч байгаа юм байна. Бид нар хууль батлах үедээ аймаг, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг унаатай байхыг зөвшөөрөөд, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг нь хасчихсан юм. Тэгэхээр үүнийг сэргээж оруулж ирж байгаа юу? Энэ чинь сумын Иргэдийн Хурлын даргын унаа биш сумын унаа байхгүй юу. Эмнэлгийн тэрэг явахаа боливол оронд нь явдаг, цагдаагийн машин явахаа байвал оронд нь явдаг ийм сумын машин байхгүй юу. Тэгээд бид нар яах вэ дээ, дарга унана гэж бодоод хасчихсан чинь нөгөө сум нь унаагүй болчихоод байгаа юм. Мөнгө нь байдаг мөнгө нь байдаг, зарцуулах боломжийг нь хаагдчихаад байгаа юм. Энэ чиглэлээр 2 дахь нь орсон уу гэсэн ийм 2 зүйлийг тодруулъя. Баярлалаа.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Булгантуяа сайд.

Х.Булгантуяа: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн албанд ахиж дэвших, мерит зарчмыг нь 2 дахин арай хөнгөн болгосон нь ерөнхийдөө бас нийгэм оролцоог хангасан хэрвээ нийгмийг бүтээе гэвэл төр өөрөө үүн дээр манлайлж эхлэх ёстой юм гэдэг л энэ зарчмыг бариад байгаа юм. Тэгээд үнэнийг хэлэхэд төрийн албан хаагчидтай ингээд уулзахад аймаг орон нутгуудын дарга нартай уулзахад энэ төрийн албаны шаардлагыг хангах хүн ер нь олдохгүй байна шүү дээ. Энэ сум, хороо дээр, анхан шатан дээр энэ тэр бол албан хаагчид зарлаад зарлаад орох орохгүй байна гэж бас бид нар өөрсдөө ярьдаг. Гэтэл үүнийг хэлэхэд энэ шалгуур бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бүр л хүнд тусаж байна. гэсэн үг.

Улсын хэмжээнд 115 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэд байж байгаагаас 4800 орчим нь өнөөдөр төрд ажиллаж байна. Үүнээс бараг 87 хувь нь төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байгаа, төрийн үйлчилгээний албан тушаалд. Үүнээс дээшээ ахиж дэвшихэд манай төрийн албаны шалгуурууд маш өндөр. Үүнд ерөөсөө тэнцэхэд үнэхээр хэцүү.

Одоо бид нар Төрийн албаны зөвлөлтэй хамтраад төрийн албаны шалгалт өгөх болзол журамд энэ хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зохицуулалт байхгүй байсныг нь өөрчлүүлж шалгалт авах байрыг нь хүртээмжтэй болгоод гээд ингээд хэдийгээр ажиллаж байгаа ч гэсэн чинь 2022 онд жишээлбэл төрийн албаны ерөнхий шалгалтад хөгжлийн бэрхшээлтэй гуравхан хүн оролцсон. Ингээд манай Архивын ерөнхий газар, Соёлын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн ерөнхий газар тус тус ажиллаж байна. Тэгэхээр энэ төрийн

албанд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллахад их хэцүү, манай төрийн байгууллагуудын зарим байрнууд үнэнийг хэлэхэд өөрсдөө ч гэсэн их хүртээмж муутай, техник тоног төхөөрөмжийн хүртээмж ч муутай. Тэгээд ажиллалаа гэхэд ахиад дээшээ ахин дэвшихэд үнэхээр хэцүү. Нэг ийм байдалтай байгааг бид нар төр өөрөө үүн дээр манлайлъя. Ганицхан хөгжлийн бэрхшээлтэй иргэд ч гэлтгүй гэж оруулж өгч байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд хэрвээ тухайн байгууллагын I дүгээр гарын үсэг зурдаг энэ даргаар байх юм бол бид бас Төрийн хэмнэлтийн хууль дээр нөгөө дэд дарга байхгүй гэдэг зүйл, заалтыг бас нэг харгалзан үзээд дэд даргатай байх боломжийг нь нээж өгье өө. Яагаад гэвэл ажлаа хийгээд зарим байгууллагуудаар явах гэхэд жишээлбэл орж гарах хаалга нь ч хэцүү. Зарим хөгжлийн бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй хүний хувьд гарын үсэг зурахад ч хэцүү байдаг юм уу ийм байдаг байх юм бол энэ бас үүд хаалгыг нь нээж өгөөд тухайн байгууллага бас асуудалгүй байна, ажиллах энэ боломж бололцоог нь нээж өгье өө гэж байгаа.

Ер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зүгээс бид нарт тавьж байгаа зүйл нь I дүгээрт, энэ хөгжлийн биет бэрхшээлтэй иргэд гэж бид нарыг ганицхан харж халамж л бид нарыг авах ёстой гэж битгий үзээч. Хөдөлмөр эрхлэх боломжоор нь бид нарыг бас хангаж өгөөч. Төр өөрөө ингээд цэрвээд хэрвээ хойшоо суугаад байх юм бол хувийн хэвшил үүн дээр бүр хэцүү шүү дээ гэдэг энэ асуудлыг бас тавиад байгаа учраас яаж ч бодогдсон манай халамжийн тэтгэмжээр хүн бол сайхан хангалуун амьдарна гэдэг бас хэцүү. Харин өнөөдөр техник, тоног төхөөрөмж шинэчлэгдээд сайжраад, ер нь нэлээдгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэрээсээ зарим нь ирж очоод ч гэсэн ажил хөдөлмөр эрхлэх бүрэн боломжтой болчихоод байгаа. Тэгэхээр энэ байдлыг нь л бид нар илүү

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хангаж өгье өө л гэж энэ удаагийн төсвийн тодотголд оруулж ирсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Хэрэг эрхлэхээс нэмж тодруулах уу? Саяын 23 дугаар зүйлийг өөрчлөхгүйгээр төрийн албаны хуулиар зохицуулалт хийх боломж байсан эсэх. Дондогмаа дарга 4 номер.

Ч.Дондогмаа: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн албанд тавигдах тусгай шаардлагыг 50 хувиар багасгаж байгаа Булгантуяа сайд сая хариуллаа. Энэ нь яг л тэр төрийн албанд ажиллах боломжийг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг тусгаж оруулж ирж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Сая зүгээр яг тодорхой асуулт асуусан шүү дээ. Заавал нөгөө Төрийн албаны тухай хуулийг хөндөхгүйгээр томилох боломж байгаагүй юм уу гэдэг асуудлыг яриад байгаа байхгүй юу. 23 дугаар зүйлийг хөндөхгүйгээр 23 дугаар зүйл чинь бол суурь зарчмын асуудал болчихоод байна гэдэг асуудал явж байгаа шүү дээ.

Ч.Дондогмаа: Төрийн албан хаагчид тавигдах шаардлагыг Төрийн албаны хуулиар яг тодорхой, зөвхөн Төрийн албаны хуулиар л тодорхой зохицуулж байгаа учраас яг зохицуулж байгаа хууль дээр нь оруулж ирж байгаа зохицуулалт байгаа.

Г.Тэмүүлэн: Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотойгоор сумын хурлын даргын унаа, тэрэгтэй холбоотой асуудал. Сумын унаа. Сангийн яамнаас хариулах уу? Жавхаа сайд.

Б.Жавхлан: Багийн дарга, тийм. Багийн дарга нарын хувьд тээврийн хэрэгсэл хэрэглэж болно л гэж байгаа. Тийм, өөр юм байхгүй.

Г.Тэмүүлэн: Сая аудитын байгууллагын холбогдох албан тушаалтнууд орж ирсэнтэй

холбогдуулаад Сандаг-Очир гишүүн түрүүн асуулт асуусан юм. Асуултыг нь та хэд сонссон байгаа юу, сонсоогүй байгаа юу? Тэгэхээр нөгөө Төрийн хэмнэлтийн хуультай холбогдуулаад аудитын байгууллагаас ямар нэг зөрчил илрүүлсэн үү, ямар нэг төрийн байгууллагууд дээр тавигдсан зөрчлүүд болоод асуудлууд үүссэн эсэх асуудал дээр бас тодорхой тайлбар мэдээлэл авъя гэсэн асуудал авч байгаа юм.

1 номер.

Үндэсний аудитын газар Наранчимэг Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 22 оны гүйцэтгэлийн тайланд бид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг дэд сэдэв болгож оруулж, Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа. Одоо хэлэлцэгдээд эхлэхээр энэ талын асуудлууд бас нэлээн тодорхой танилцагдах байх гэж ингэж бодож байна.

Бид нар аудитын тайландаа Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр төсвийг арвилан хэмнэлт үр ашигтай зарцуулах эрх зүйн орчин бүрдсэн байна гэдгийг дүгнэж өгсөн. Аудитаар нийтдээ 61,6 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн, 1,5 тэрбум төгрөгт төлбөрийн акт тогтоосон.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр нийтдээ 137 тэрбум төгрөгийг зарцуулаагүй. Энэ бол бас зарцуулаагүй байгаа. Яг хориглосон заалттай холбоотойгоор дэд дарга, орлогч, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа гэдэгтэй холбогдуулж 29,8 тэрбум төгрөгийг яг энэ хориглосон заалтуудтай холбоотой бодит хэмнэлтийг гаргасан. Тэгэхдээ аудит хийгээд явж байхад Төрийн хэмнэлтийн тухай хууль гарснаар Монгол Улсын Ерөнхий аудитор энэ Төрийн хэмнэлтийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

тухай хуулийг аудитын байгууллага хянахдаа ямар зүйлд анхаарах вэ гэдгээр нэгдсэн бодлого чиглэлээ гаргаж бүх аудиторрууддаа хүргүүлсэн. Хуулийн ямар зүйл, заалт дээр төлбөрийн акт тогтоох юм, ямар зүйл, заалт дээр албан шаардлага өгөх юм, ямар дээр нь зөвлөмж өгөх юм гээд нэгдсэн бодлого чиглэлтэй энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үзсэн. Гэхдээ Төрийн нэмэлтийн тухай хуулийг өөрчлөх шаардлага байна гэдгийг аудитын байгууллагаас Улсын Их Хуралд толилуулсан. Тодорхойгүй заалтууд байна. Төрийн өмчит хувьцаат компаниуд дээр хэрэгжих боломжгүй асуудлууд байна. Саяын тэр гишүүдийн яриад байгаа унаа, тэрэгний асуудлууд байна, сургалтын асуудлууд байна. Ингээд тодорхойгүй нэлээдгүй заалтууд байгаа учраас өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага байгаа юм байна гэдгийг Улсын Их Хуралд толилуулсан. Энэ өргөн барьсан тайланд тодорхой дэд бүлэг болоод орчихсон байгаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа.
Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа.
Тэгэхээр Улсын төсвийн тухай хуульд өөрчлөлт орж байгаатай холбогдуулж дагуулж өргөн барьсан хууль, тогтоолын төслүүд байгаад байгаа юм. Тэгэхээр үндсэндээ бид нарын ярьж занисанаар энэ тодотголтой холбоотой л асуудлууд уул нь дагаж орж ирмээр. Гэтэл яг том бодлогын түвшний асуудлууд дагаад ороод ирчхээд болж өгөхгүй байна л даа. Жишээ нь энэ Төрийн албаны тухай хуульд орж ирчхээд байгаа өөрчлөлт бол яг нарийндаа нэлээн том судалгаа, дүн шинжилгээ хийж, төрийн байгууллагын өөрийнх нь бүтэц, чиг үүрэг, ямар чиг үүргүүдээ бусдаар гүйцэтгүүлж болох юм энэ тэр гэдэг энэ бүх юмаа тооцож үзэж байж, сая үзэл баримтлал нь тодорхой болох ёстой асуудлууд орж ирчхээд байгаа юм. 15 хувь байя. Тэгээд оны дараалалдаа оруулаад тэдэн онд тэдэн хувьтай байя энэ тэр гээд орж ирчхээд байгаа энэ заалтууд бол тийм, үндсэндээ

судалгаа тооцоолол нь хэр хангагдсан юм, би ойлгохгүй байгаа, яг үнэнийг хэлэхэд. Үүн дээр нэг тодорхой хариулт авмаар байна гэж.

2 дугаарт, энэ төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлийн асуудал бол 68 хувиас давдаггүй байсан. Одоо бид 100 гэж яриад тэгээд дээр нь орон нутгийн нэмэгдэл энэ 100 дотроо орохгүй гэсэн ийм үг орчхоод яваад байгаа юм. Энэ хаанаас яаж тооцоолол хийсэн судалгаагаар гарч ирсэн хувь бэ? Үүн дээрээ нэг тодорхой хариулт өгөөч гэж.

3 дахь зүйл. Ер нь тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах дан дамаа тэр өөрийнхөө чиг үүрэг хэрэгжүүлж байгаа агентлагаа толгойлох асуудлыг шийдэж болох байх. Гэхдээ тавигддаг шалгуур шаардлага нь нэгдсэн 1 байх, байх. Тэр битгий хэл өөрийнх нь бэрхшээлээс хамаараад орлогчийн тухай асуудал гаргаж ирж байгаа юм байна лээ. Энэ судалгаа юмнууд чинь хэр тооцоололтой хийгдсэн юм бэ гээд. Энэ Төрийн албаны тухай хууль дээр нэг ийм хэд хэдэн тодруулах зайлшгүй шаардлага байна гэсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хууль дээр асуудал байгаад байгаа юм. Дан дамаа энэ 4 дүгээр зүйл чинь бол яг нарийндаа та хэдийн ярьж байгаагаас өөр болоод байгаа. 8.1 дэх заалт чинь болохоор зэрэг тодорхой байгууллагуудын нэр хэлээд эд нар бол дүрэмт хувцастай байна, үүнээс өөр албан хаагчид дүрэмт хувцастай байхыг хориглоно гээд хэлчихсэн. Тэгээд 8.2-оороо бол энэ энэ байгууллагуудын энэ хувцас 8.1-дээ хамаарахгүй ээ гэсэн заалт л байсан байхгүй юу. Тэгэхээр зэрэг 8.2-ыг хасна гээд хасчих юм бол энэ эмч нар чинь ямар хувцастай тэр эмнэлгийн ажил үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар хамгааллын асуудлаа барих юм бэ. Зарим нь бол яг хөдөлмөрийн аюулгүй байдалтайгаа хамаарагдах хувцас байгаа. Зарим нь яах аргагүй өөрсдийнх нь эрүүл ахуй элдэв бусын юмтайгаа холбоотой хувцаснууд

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байгаад байгаа. Тэгэхээр үүнийг ингэж хасах юм бол наадах чинь боломгүй зүйл байна. Хөдөлмөр хамгааллын хувцас гэдэгтээ яг нэр дурдагдаж ороогүй байж болохоор ийм зүйл заалтууд байгаад байгаа байхгүй юу. Тийм учраас үүнийг ямар тооцоо судалгаатай та бүхэн маань оруулаад ирэв ээ гэдэг нэг ийм асуудал байна.

Дараагийн хууль нь болохоор тэр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулаад байгаа юм. Түүний тэр 40.6 дахь заалт юм. Энэ ер нь яг нарийндаа энэ заалтаар бид нарын тавиад байгаа зорилго, зорилт хангагдах юм уу. Ер нь эс үгүй бол зөвлөлийн хэлбэрээрээ хангагдах юм уу. Хөгжлийн бэрхшээлийн асуудал бол маш олон асуудлуудаар гарч ирдэг. Харааны гэдэг юм уу, сонсголын гэдэг юм уу, тулах эрхтний гэдэг юм уу өчнөөн юм бий. Тэгвэл энэ улсуудын төлөөллийг хангасан зөвлөл агент ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Булгаа сайд хариулах уу.

Төрийн албаны хуулийн 15 хувь болгож бууруулж байгаа, тооцоо судалгаа нь хэр хангалттай эсэх гэдэг асуудал байгаа. Хоёрдугаарх нь төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэл 100 хувь гэж нэг үг үсэгтэй орж ирсэн. Энэ чинь бас хэр тооцоотой хийгдсэн эсэх? Эхний асуулт 4 номер. Хэрэг эрхлэх газраас хариулах уу? Тэгээд залгуулаад Булгантуяа сайд нэмэлт хариулт өгөөд. 4 номер.

Ч.Дондогмаа: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор төрийн албан хаагчийн тоонд хязгаар тавих асуудлыг Хэрэг эрхлэх газар дээр ажлын хэсэг байгуулагдаад судалсан. Энэ дээр сүүлийн 2019 оноос хойш 2022 оныг хүртэл төрийн албан хаагчийн тоо 52 хувиар нэмэгдсэн гэсэн тооцоолол гарсан байгаа. Үүнтэй холбогдуулаад энэ эдийн

засгийн хамтын ажиллагааны хөгжлийн гишүүн орнуудын төрийн албан хаагчийнхаа тоог ажиллах хүчнийхээ тоотой уялдуулан тогтоодог жишгийг баримтлаад манай улсын хувьд нийт ажиллах хүчнийхээ тоотой уялдуулахад 15 хувь дээр байх ёстой юм байна гэсэн судалгаа гарсан юм. Тэгээд энэ 15 хувь дээр барих энэ зохицуулалтаа бол үе шаттайгаар хэрэгжүүлэхээр 2026 оны 01 сарын 01 хүртэл 15 хувь дээр барих ийм үе шаттай бууруулах зохицуулалтыг Төрийн албаны хууль дээр дагаж мөрдөх журмын зохицуулалтаар тусгасан байгаа юм.

Г.Тэмүүлэн: Нэмэгдлийн хувийг Булгантуяа сайд хариулах уу? Булгантуяа сайд. Санжаа дарга уу? Санжаа дарга 4 номер.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж Батжаргал гишүүний асуултад хариулъя. Нэмэгдлийн хувь хэмжээ бол бид 2 жилийн өмнө хийсэн тооцоогоор үндсэн цалинтай нь харьцуулахад 67 хувь дунджаар байгаад байгаа юм. Тэгэхээр дундаж гэдэг маань өөрөөр хэлбэл тэрнээсээ өндөр ч байгаад байна, бага ч байгаад байна гэсэн тийм асуудал болчхоод байгаа юм. Одоо бид нар нөгөө цалингаа өсгөөд явахаар нөгөө цалин үндсэн цалингаасаа нэмэгдэл бодогддог учраас энэ маань маш ихээр нэмэгдэх ийм нөхцөл байдал үүсэх боломжтой болчхоод байгаа юм. Нэг дэх асуудал, үндэслэл нь.

2 дахь үндэслэл нь ямар юм болоод байна гэхлээр салбар болгоны хувьд үндсэн цалин ингээд сүүлийн 2, 3 жил нэмэгдээгүй. Өмнө нь ч бас эдийн засгийн хүндрэлтэй үед үндсэн цалин нэмэхгүй явахаар зөвхөн салбарын хуулиуд дээрээ өөрийн салбарын онцлогтой нэмэгдлүүдийг нэмж оруулаад байдаг. Гэтэл бодлогын хувьд бид нар нөгөө цалин хөлсийг илүү бүтээмжтэй нь үр дүнтэй нь уях хэрэгтэй байгаад байдаг. Тэгтэл тогтмол цалинтай буюу орцод суурилсан манай цалингийн бүтэц болчхоод байдаг.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Өөрөөр хэлбэл жишээ нь төрийн захиргааны албан хаагчийн хувьд бол ажилласан жилийн нэмэгдэл байна. Зэрэг дэвийн нэмэгдэл байна. Мастерын зэрэгтэй бол мастерын нэмэгдэл байдаг ч юм уу тийм ээ. Дээрээс нь мэргэшсэн нягтлан бол мэргэшсэн нягтлангийн нэмэгдэл буюу ямар ч хийсэн ажилтай нь үл хамаарах ийм нэмэгдлүүд байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар аль болох тогтмол нэмэгдлүүдээ бол хязгаарлаж тодорхой хэмжээнд хязгаарлаад тэгээд бүтээмжид суурилсан буюу үр дүнд суурилсан нэмэгдлүүдээ тусад нь явуулах нь зүйтэй юм байна гэж үзээд байгаа юм. Энэ тогтмол нэмэгдлүүдтэй бас уялдаж түрүүний таны асуусан яг орон орон нутгийн нэмэгдэл бас байгаа. Орон нутгийн нэмэгдлийн хувьд хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд бол 100 хувийн нэмэгдэлдээ орчих юм бол хөдөөгийн нөгөө албан хаагчид маань нийслэлийн албан хаагчдын хувьд ялгаагүй 100 хувь дээр очоод гацчих ийм зүйл гарчхаад байгаа.

Мэдээж хэрэг 67-г 100 хувь руу бид нар ингээд өсгөөд орж ирж байгаа асуудал орж ирж байгаа. Өмнө нь өмнөх Төрийн албаны тухай хууль дээр бид нар энэ 67 хувь гэдгийг оруулж ирж байсан юм. Нийт цалин хөлсний нийт сангийнх нь 40 хувийн нэмэгдлээс хэтрэхгүй байна гэдэг агуулга. Гэхдээ шинэ Төрийн албаны тухай хууль батлагдахдаа бол энэ агуулга байхгүй болж орж ирсэн. Шалтгаан нь бол яг түрүүний хэлдэг зарим хүмүүсийн нэмэгдэл хэт өндөр байгаад байдаг, зарим нь бага байгаад байдаг. Одоо Хөдөлмөрийн тухай хуулиар бол хүний хүрсэн цалин хөлсний үнэлэмжийг буюу хүний цалин хөлсний тэр хүрсэн хэмжээг бууруулж болохгүй тийм зарчим байгаад байдаг. Тэр агуулгаар нь бид нар дундажлаад 100 хувьд хязгаарлая. Өөрөөр хэлбэл тухайн албан хаагчийн цалин сая 500 мянган төгрөг байвал тогтмол нэмэгдэл нь дахиад сая 500-аас хэтэрч болохгүй ээ, 100 хувийн нэмэгдэл.

Үүнээс цаашаа дахиж нэмэгдэл ярих бол зөвхөн бүтээмжид суурилсан. Тэр хүн юу хийсэн бэ, яаж ажилласан бэ гэдэг энэ асуудлуудаа явъя. 100 хувийн нэмэгдэлдээ бол энэ Төрийн албаны хуульд заасан энэ мерит зарчимд заасан энэ цолны нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдлүүд бүх энэ нэмэгдлүүдээ багтаая л гэдэг ийм агуулга оруулж ирсэн юм. Тийм.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн нэмж тодруулах уу? Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой асуулт асуусан. 8.1 дэх заалт 8.2-той холбоотой эмч нарын хувцас хэрэглэл, хөдөлмөр хамгааллын хувцас, тоон судалгаа байгаа эсэх гээд. Санжаадорж дарга 4 номер.

М.Санжаадорж: Төрийн хэмнэлтийн тухай хууль дээр орж байгаа өөрчлөлт нь бол яг заалтыг нь та ингээд үзэх юм бол нөгөө шүүгчийн тэр өмсгөл гэдгээс хойшоо эмчийн тэр халат энэ тэр гээд хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой тэр хэсгүүдийг нь бид нар энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулиас хасчхаж байгаа юм. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой энэ хэсэг, одоо бээлий, халат юу гэдэг юм каск энэ бүх зүйлүүд нь хасагдчихаар хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой хэсэг нь Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийнхаа том хуулиараа зохицуулагдаад явна. Тэр нь норм, нормынх нь дагуу л олгогдоод явна гэсэн байдлаар бид нар томъёолж оруулж ирсэн байгаа. Үүнийг илүү тодорхой болгох асуудал ярих юм бол мэдээж хэрэг ажлын хэсгийн хүрээнд яриад явчхаж болно.

Түүнээс биш Засгийн газрын зүгээс мэдээж хэрэг эмч нарыг халаадгүй болгохоор ч юм уу тийм байдлаар оруулж ирсэн тийм зүйл байхгүй. Илүү хөдөлмөрийн аюулгүй байдал, тэр норм нормтой, стандарттай зүйлүүдийг нь илүү хэмнэлтийн хуулиас бид нар хэмнэлтийн хуулиар зохицуулахгүй байхаар л ... /минут дуусав/

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн нэмж тодруулъя. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчдын тооны өсөлт энэ тэр гээд юм ярихаар бас их зөв ярихгүй бол нийгэмд буруу ойлголт өгөөд байгаа юм. Төрийн албан хаагчдын тооны өсөлт чинь ерөөсөө энэ хамран сургалтаа нэмэгдүүлэх гээд, юу сургуулийнхаа ээлжийг бууруулах гээд, шинээр барьсан сургууль цэцэрлэгтэй чинь л холбоотой өсөлт байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр үүнийг бид яаж бууруулдаг юм, яаж барьдаг юм. Тодорхой чиг үүргүүдээ хувийн хэвшилээр гэдэг юм уу бусдаар гүйцэтгүүлэх чиг үүргийн зохицуулалт хийж байж л асуудал ярина уу гэхээс биш. Тэгэхээр ийм юмнуудыг бол судалгаа тооцооллыг нь илүүтэй нарийсгахаас өөр арга бидэнд байхгүй. Үүнийгээ эргэж хараач ээ гэдэг ийм санал байна.

Та нар эрүүл мэнд, байгаль орчин, зам тээвэр гээд хэмнэлтийн хууль дээр орж ирж байгаа юм. Байгаль орчны байцаагч нар зайлуул нэг тийм ерөнхий дүрэмт хувцастай. Үүнийг нь та нар аваад хаячихаар зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой хувцас биш. Тэр бол үндсэндээ байгаль орчин хамгаалах чиглэлээр түмэнтэй мөнхийн харьцаж байгаа улсууд. Нэгдсэн 1 хувцастай байхгүй бол нударгатай дээлтэй нөхөр хэрүүл хийгээд явж болохгүй байлгүй дээ. Тэгэхээр ийм байдлаар асуудалд хандамгүй байна. Үүнийгээ эргэж хараач ээ гэдэг ийм саналыг би зориуд хэлмээр байна.

Дараагийн нэг тодруулмаар байгаа зүйл бол энэ тогтоол дээр байгаад байгаа юм. Энэ хүүхдийн мөнгийг заавал хүсэлт гаргасан гэж хэлэх юм уу даа, хэдүүлээ тэртээ тэргүй төсөвт мөнгийг нь суулгачихлаа. Түүнийг нь олгодог хэлбэрээр нь олгох хэлбэрээр нь явчихмаар байна. Тэртээ тэргүй наадуул чинь дансаа өгөхөөр тэр нь хүсэлт болох юм

байгаа биз дээ? Тийм хүсэлтээ гаргасан улсуудынх нь данс руу л мөнгө орно шүү. Тэгэхээр энэ нэршил дээрээ заавал тэр хүсэлт гаргасан гэдэг үг байгаад байх хэрэг байна уу? Төсвийн тодотголоороо мөнгөн дүнг нь тов тодорхой гүйцэд тавиад л өгчихсөн.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний сүүлийн асуултад хариулъя. Хүүхдийн мөнгөтэй холбоотой хэн хариулах вэ? Санжаадорж. Санжаа юу. Хариулах хүн байна уу? Гараа өргөөрэй. Булгантуяа сайд асуултад хариулах уу, Батжаргал гишүүний.

Х.Булгантуяа: Харин тийм. Тэгэхээр түүнийг нөгөө бид нарт холбохын тулд 1 дүгээрт хүсэлт иргэн өөрөө 1 дүгээрт хүсэлт тавих хэрэгтэй байна. гээд. Яах вэ 2 дугаарт энэ бас манай Сангийн яамны хувьд энэ ОУВС-аас авхуулаад олон улсын байгууллагуудад бас нэг бид нар халамжаа бас нэг аажим аажмаар бууруулж байгаа гэж харуулах бас нэг үзүүлэлт болчихоод байгаа юм байна лээ. Түүнээс нэг их мөнгө хэмнэхдээ биш. Зүгээр одоо манай бараг хүүхдэдээ нийт өрх жишээлбэл энэ нөгөө халамж гэдэг зардал дээр яваад байгаа учраас эс үгүй бол бид нар бүр зардлын ангиллаа, эс үгүй бол энэ байгалийн баялгийн хуваарилалт ч гэдэг юм уу тэгж ер нь яваандаа энэ төсөв дээрээ өөрсдөө солих ёстой юм байна лээ. Тэгэхгүй бол одоогийнхоор бол ингээд халамж гээд тэгчхээд 9 хувь дээрээ яваад, өмнө нь үнэнийг хэлэхэд 10 хувь нь бол 100 хувь олгож байхад огт авдаггүй байсан, бүртгүүлдэггүй байсан. Тэгэхээр магадгүй энэ түрүүн Чинзориг гишүүн ч гэсэндээ бас сайд бас барьж байна лээ. Улсын Их Хурлын гишүүдээс авхуулаад ч байдаг юм уу зарим нэг нэлээн боломжтой энэ хүмүүс нь авахгүй гэх бас юу байгаа байлгүй дээ? Тийм хүсэлт байгаа байлгүй, ардчилсан нийгэмд. Түүнийг нь л зүгээр нээгээд өгчихье. Харин бид нар яах вэ, арай нэг жоохон хөнгөн байдлаар үүнийг нь зохион байгуулъя.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

9 хувь дээр нь эс үгүй бол авах гэж байгаа хүмүүс нь биш 9 хувь дотроо би үүнийг Хүүхдийн сан руу байдаг юм уу хандивлая гэсэн хүмүүс нь ороод л, клик хийгээд л, цахимаар дарахад л байдаг юм уу, эс үгүй бол Хөдөлмөр халамж дээр очоод л түүнийг мэдүүлэхэд л цаашаагаа Хүүхдийн сан руу ордог байя гээд. Хүүхдийн санг ингээд бусад сангуудтай адилхан тэр чигээр нь тоночихсон юм шиг тийм ойлголт байж болохгүй. Энэ угаасаа үүсгэн байгуулагдсан цагаасаа авхуулаад 11 тэрбум төгрөг хуримтлагдсан юм байна лээ. Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газраас тухайн үед нь бас бага багахан байгаа мөнгийг нь үрээд юу гэх вэ. Нэг овоо мөнгө хуримтлагдахаар нь дорвитой бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтад оруулъя гээд одоо хүртэл төсөв санхүүжилтийг нь огт бараг зарцуулаагүй байгаа.

Г.Тэмүүлэн: Булгантуяа сайд нэмээд хариулъя.

Х.Булгантуяа: Энэ нөгөө азын дугаараас авхуулаад иргэдээс хандивласан мөнгө төгрөг нь бас 11 тэрбумаас 1 тэрбум арай хүрэхгүй дээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэх мэтчилэн тэмцээн уралдаанд орохтой холбоотойгоор шийдвэрлэсэн зарцуулсан зүйл байгаа. Өөр ерөөсөө бусад нь огт зарцуулагдаагүйгээр 10 тэрбум гаруй төгрөг нь яг тэр чигээрээ байж байгаа. Манай сангууд дотроос хамгийн сайн харин зарцуулалт ч огт бараг хийгээгүй, шийдвэрийг нь нэлээн хуримтлал үүсгэж байгаад дорвитойгоор гаргая гээд өнөөдрийг болтол мөнгө нь бүрэн бүтэн байж байгаа сан байж байгаа. Тэгээд үүнийг бид нар бас Ерөнхий сайдын ахалдаг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл дээр хүүхдийн төрийн бус байгууллагууд ажиллаж байгаа. Эдгээр байгууллагууд өөрснөө бас санал гаргаад хүсэх юм бол олон нийтийн дунд ч гэсэн хэлэлцүүлэг өрнүүлж байгаад хүүхдийн төлөө дорвитойхон шиг бүтээн байгуулалт хийе ээ гэж байгаа юм.

Энэ азын дугаараас жилд 5 тэрбум төгрөг арай хүрэхгүй л орж ирдэг юм байна лээ. 3, 4 тэрбум төгрөг л орж ирдэг юм байна лээ. Тэгэхээр бид бас үүн дээр зүгээр 1 хувь л үнээс татгалзахад л маш их дүн шүү дээ. Тэгэхээр үүгээр 1 хувь татгалзахад нэг сургууль байхгүй юу. 1 хувь хүүхдийн мөнгөнөөс иргэдээс 1 хувь нь татгалзахад 1 сургууль болно гэдэг л ийм өнцгөөр л бас зарим нэг хүмүүс хандивлахыг бид нар үгүйсгэхгүй. Тэр сонголтыг нь олгоё л гэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн асуулт асууя.

Ш.Раднаасэд: Энэ төрийн албатай холбоотой нэг өөрчлөлтийг бид нар чухам аль зүйл дээр нь хийх ёстой юм, нэг юм хийхгүй бол энэ цааш цаашидаа энэ Монголын төрд хэрэгтэй л дээ. Энэ бүтэц их ойр ойрхон хийдэг, үүнийг хуулиар биш өндөр квоттой болгодог юм уу. Зайлишгүй бүтэц хийлгэхгүй байдал гээд л юу яахгүй юу. Сайд очно, сайд болгон очоод л бүтцээ хийнэ. Одоо бүх яамнууд хийж байна. Мэргэжлийн хяналт ирлээ гэж хэлээд л бүр бүхэлд нь газруудаа бужигнуулаад л дахиад. Үүнээс чинь болж маш олон төрийн албан хаагчид энэ төрөөс чинь явж байгаа байхгүй юу. Тийм учраас нөгөө шаардлага хангах хүн олдохгүй байна гэдэг чинь энэ. Тэгээд дандаа шинэ залуу хүмүүс аваад ирдэг нөгөөдөх нь шаардлагаа хангадаггүй. Байгаль орчны яам гэхэд 20 оноос хойш 4 удаа, жил болгон, 4 жил дараалан бүтэц хийж байна шүү дээ. Жишээлэх юм бол. Бараг энэ сайд нар нь олон хөдөлсөн яамнууд бүгд тийм байгаа. Үүнийг хууль дээр нэг тогтвортой, төрийн албаа тогтвортой байлгая, энэ мэргэшсэн байлгая гэж байгаа бол үүнийгээ эхэлж хийсний дараа бид нар энэ хүмүүсийн асуудлыг ярих ёстой байх. Надад бол суурь юм чинь энэ л юм шиг харагдаж байгаа юм. Өөрөөр бол халж чаддаггүй. Тэгээд бүтцийн өөрчлөлт хийлээ, уучлаарай, ингээд өөрийг чинь энэ газар луу тэр газар луу шилжүүлээ гээд доош нь, дээш нь гүйлгээд байдаг. Түүнээс чинь хамаараад

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

энэ хүмүүс яваад байна. Энэ ажлын хэсэг дээр бодвол байгуулагдах байх, байгуулагдсан байгаа билүү үү, ерөөсөө ажлын хэсэггүй явж байгаа билүү. Энэ аль зүйл дээр байдаг юм, Төрийн албаны хууль дээр үүнийг хийж өгөөд энэ 24 оноос хойш үүнийг энэ бүтцийг хамаагүй оролддогийг нь зогсоолгохгүй бол энэ чинь ерөөсөө үзэмжээрээ явж байгаа байхгүй юу. Тэгээд хийх ёсгүй газар эд нар чинь Ерөнхий сайд дээрээ ороод л ёстой болохгүй байна ингэхгүй бол ерөөсөө энэ ажил унаад байна, ингээд байна гэж жаал гоё гоё юм ярьж байгаад л нэг юм хийгээд л түүний цаана нэг жаал ямар ч мэргэжлийн ойлголт хуучин байгаа хүнээсээ дордуулсан хүмүүсийг авчраад ингээд тавиад, тавиад явчихсан. Энэ бол түүнтэй л холбоотой. Тэгээд түүнээсээ мултрахын тулд ингээд шалгуур шаардлагууд байх, хөнгөлөөд жижгэрүүлээд ингээд л явж байгаа ийм хэлбэр байх шиг байгаа юм.

2 дугаарт, энэ аудитын тайлантай холбоотой энд чинь би л лав итгэл үнэмшил байхгүй болчихсон. Аудитын байгууллагад. Нийслэлийн аудитын газрын дарга Наранчимэг гэж ямар хүн байдаг юм, өөрөө юу. Одоо Говь-Алтай аймаг, Алтай Улиастай компанийн хийлгэсэн гэрээт аудит нь зөрчилгүй гээд бичиг оччихсон байхад таныг утас цохингуут нөгөө компани нь зөрчилтэй болж хувирдаг. Ийм юм байж болдог юм уу? Тэгээд зөвхөн тэр компанийн захирлыг солихын тулд ингээж аудитын тайлан дээр засвар хийдэг юм байдаг юм уу? Надад тэр баримт цаас нь бүгд байгаа учраас би яриад байна. Тэгэхээр энэ та нарын хийчихсэн энэ аудитын тайланд чинь хэн итгэх юм бэ? Энэ зүгээр дарга нарын үзэмж ордог ийм юм болчихоод байна шүү дээ. Энэ хэмнэлтийн хууль дээр хийсэн л гэж байна, хаана тэрэнд чинь яаж итгэх юм. Одоо энэ аяган дээр нэгдье гээд нэг ийм цаас наагаад явж байна шүү дээ. Тэр АТГ нь. Дэлгүүрт зарж байгаа усан дээр нэгдье гээд ийм лого өлгөчихсөн байна шүү дээ. Төр ийм байдлаар сурталчилгаа хийж болдог юм уу. Тэгээд

түүнийг та нар хэмнэлт гэж хэмнээгүй гэх юм уу, хэмнэсэн гэж тайланд тавьсан юм уу, энэ дээр. Энэ дотор чинь итгэх юм аягүй бага байгаа. Би бол аудитыг бас овоо гайгүй юм болов уу гэсэн. Сүүлд бас энэ үйл явдлаас хойш байдлыг чинь харахад та нар бол шал худлаа ажилладаг юм байна л гэж. Тэгэхээр хүмүүсийнхээ тоог нэмдэг.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүний микрофоныг 1 минут нэмье.

Ш.Раднаасэд: Тэгээд энд байгаа энэ аудит ч бай, энэ дарга нараас чинь болоод ингээд энэ төрийн албан хаагч чинь хохироод л явж байгаа байхгүй юу. Тэгээд тэрэнд нь таарсан тохирсон хүнийг нь тавихын тулд энэ нөгөө мэргэжлийн зэргийг нь доошлуулдаг, тавьдаг. Энэ төрийн албаны шинэчлэл хуультайгаа холбоотой доошоо бол түмэн нугараад нугалаад явсан шүү, нугалаад явсан шүү. Та нар тэр нийслэлийн аудит, үр дүнгийн аудит хийсэн бол. Одоо тэр 2 сая 600 мянган төгрөгөөр төлөөд тэр нэг тэргүүн дэд зэргийн түүмэлийн сертификат авна гээд ингээд төр хүнээ тэгж бэлддэг үү, мөнгөгүй нь яах юм. Тэгээд тэрэнд нь суухгүй, хэзээ ч тушаал дэвшихгүй. Тэгээд нөгөө мерит зарчим чинь сүүлдээ мөнгө болж байна шүү дээ, Удирдлагын академи дээр очоод. Төрийн нарийн бичгийн дарга болохын тулд эс үгүй бол нэг агентлаг, яаманд газрын дарга болохын тулд зайлшгүй ийм мэргэжлийн үнэмлэхтэй байх ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Бараг санал хэллээ. Аудитын асуудал, аудитын санхүүгийн тайлан дараагийн асуудал байгаа. Тэрэндээ тодорхой бас тайлбар мэдээллүүд өгөөрэй. Аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан байгаа.

Би зүгээр нэг ганцхан юм асуугаадахъя. Харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн дарга Батцэцэг дарга байна. Харилцаа холбооны тухай хуульд

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл орж ирсэн байна. 7 хууль дотор. Энэ дотор ерөөсөө ганцхан заалт байх юм. Харилцаа холбооны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн 9.10 гэснийг хассугай гэсэн заалт байгаа. Энэ яг ямар заалт болоод үүнийг хасаад байгаа юм бэ? Яагаад энэ өөрчлөлт оруулах шаардлага гарсан юм бол.

12.4 дэх буюу та бүхний хөндөж оруулж ирсэн энэ заалт маань 23 оныхоо 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан заалт байгаад байгаа юм. Тэгээд нөгөө түрүүн яриад байдаг дөнгөж бийр нь хатаж амжаагүй байхад л буцаад л өөрчлөлт оруулах асуудлууд орж ирээд байдаг. Хууль бараг батлагдах шатад явж байгаад л дахиж өөрчлөх асуудлууд орж ирээд байдаг. Яагаад энэ заалтыг оруулж ирэв ээ? Энэ тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэхтэй холбоотой л баримт бичигтэй холбоотой асуудал байх шиг байгаа юм.

Батцэцэг төрийн нарийн хариулъя, 7 номер.

Б.Батцэцэг: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Харилцаа холбооны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дээр, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10-д Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсгийг хасах гэсэн заалтыг оруулсан байгаа. Энэ маань юутай холбоотой вэ гэхээр 2007 онд Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоолоор харилцаа холбооны салбарын сүлжээ, сүлжээний үйлчилгээ, сүлжээ үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг салгасан юм байна лээ. Энэ бас олон улсын хувьд бас ийм зохицуулалтууд явж байсан. Сүүлийн жилүүдэд болохоороо нам орбитын хиймэл дагуулын сүлжээг ашиглан интернэтийн үйлчилгээ үзүүлэх, ялангуяа үүнийг судалгаа шинжилгээнд ашиглах нөхцөлүүд үүсээд байгаа. Энэ дээр Америк, Нидерланд, Канад зэрэг олон улсын бусад томоохон улсуудын

томоохон компаниуд үйл ажиллагаагаа эрхлээд явуулж байгаа.

Өнгөрсөн жилээс хойш Старлинг компани Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулах зөвшөөрлийг албан бусаар болон албаар албан журмаар хүсэлт тавьсан. Энэ нь Старлинг компанийн үйлчилгээ Монгол Улсад нэвтэрснээр ямар ач холбогдолтой вэ гэхээр Монгол Улсын өргөн уудам тархсан газар нутагт, тархан суурьшсан иргэдэд интернэтийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх асуудал нь зөвхөн шилэн кабель тавиад яваад байхаар зардал өндөртэй. Тэгэхээр энэ нөгөө нам орбитын хиймэл дагуулын интернэтийн сүлжээ ашиглачих юм бол зардал хамаагүй багасна. Дээрээс нь гамигийн үед байдаг юм уу эс үгүй бол тархан суурьшсан малчдад мэдээллийг түргэн шуурхай түгээх зэргээр өндөр ач холбогдолтой гэж үзэж байгаа.

Бид яагаад Старлинг гэдэг компанийг онцлоод байна вэ гэхээр манайд одоо хүсэлтээ бас илэрхийлээд байгаа компанийнх нь хувьд онцлоод байгаа. Түүнээс биш Америк, Канад, Нидерланд улсын бас томоохон компаниуд байгаа. Энэ байгууллагууд Монгол Улсад интернэтийн сүлжээний болон үйлчилгээ эрхлэх боломжийг нь олгож байгаа ийм зохицуулалт орж ирж байгаа.

Энд 23 онд орсон өөрчлөлт нь болохоороо Зөвшөөрлийн хууль дагаж орсон юм байна лээ. Тэгээд энэ дээр саяхан Засгийн газрын түвшинд ярилцаад Төсвийн хуулийг дагуулаад энэ яг сансрын холбооны үйлчилгээ эрхлэх нь болохоороо үйлчилгээ, сүлжээг нь аль алийг нь нэг компанид тусгай зөвшөөрөл эзэмшүүлж болно гэдэг зохицуулалт орж ирж байгаа.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр энэ удаагийн төсвийн тодотголтой сая зардал хэмнэх үндсэн дээр энэ заалтыг оруулж ирж байгаа гэж ойлгож болох уу? Хэр хэмжээний зардал хэмнэх гэдэг юм уу төсвийн тодотгол дээр ер нь ямар нөлөө

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

үзүүлэх юм? Энэ оны төсөвтэй холбоотой. 7 номер.

Б.Батцэцэг: Яг ямар байдлаар нам орбит маань, орбитын станцууд маань хаана хаана байрлах гэдэг нь бас тодорхойгүй байгаа. Яг албан ёсны хүсэлт нь бид нарт ирээгүй байна. Монгол Улсын Ерөнхий сайдын Старлинг компанийн төлөөлөлтэй уулзсан уулзалтын үр дүнгээр Монгол Улсад тун удахгүй Харилцаа холбооны зохицуулах газраас хорооноос шаарддаг бичиг баримтыг албан ёсоор хүсэлтээ тавиад тэгээд орж ирнэ, хуваарилалт хийгдэнэ. Үүний дараа бас төсөв дээр ямар хэмжээний хэмнэлт гарах вэ, ямар хэмжээний зардал гарах вэ гэдэг нь тодорхой болно.

Г.Тэмүүлэн: Ойлголоо.

Хуулийн төслүүдтэй холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа.

Хууль, тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Сандаг-Очир гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр түрүүний хэлсэн асуусан асуулттайгаа л холбогдож байна л даа. Хэдүүлээ энэ Төрийн албаны тухай хуульд оруулж байгаа өөрчлөлтөө нэлээн судалж байж хийвэл яасан юм бэ? Үүнийг тодорхой хувь ярьж байна, он цагийн дарааллаар хэрэгжүүлэх гэж оролдож байна. Бас босго, шаардлагуудыг тодорхой сулруулж байгаа юмнууд байна. Тэр нэг нэмэгдлийн хувь энэ тэр гээд энэ юмнуудыг ер нь жсоохон судалбал яасан юм. Энэ удаагийн төсвийн тодотголд энэ заалтууд нэг их төдийлөн хамаарал багатай. Бид тэртээ тэргүй байгаа улсдаа үндсэн цалинг нь ингэж нэмье гээд шийдлээ гаргачихлаа, олгодог хэлбэр нь байж байна. Тэгээд тодорхой хугацаанд судалж нэлээн бодитой болгож гаргаж ирсэн нь дээр байх. Тийм учраас би төсөл

өргөн баригчийг энэ асуудалдаа нэлээн нухацтай хандана болов уу гэж харж байна.

2 дахь зүйл. Төрийн хэмнэлтийн тухай хуульд оруулж байгаа өөрчлөлттэй холбоотой тэр 4 дүгээр зүйлээ бид авчихсан нь дээр. Тэгэхгүй бол энэ дан ганц хөдөлмөр хамгааллын хувцас гэдэг нэр нь ангилалд орохооргүй тэгээд байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой хувцас, хунарын асуудал дээр тодорхой хүндрэл үүсэж болохоор байгаа юм. Та бүгдийн энэ 4 дүгээр зүйл чинь бол 8.1 дэх заалтдаа хамаарахгүй гэсэн 2 дахь заалтаа бид хүчингүй болгоод байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг үүнийгээ эргэж харах нь зөв байх гэж нэг ийм санал хэлмээр байна гэж.

Дараагийн нэг хэлчихмээр байгаа санаа бол тэр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн оруулж байгаа өөрчлөлтийн 40.6-г бид эргэж хармаар юм билээ. Агентлагийг ганц хүн толгойлсноор асуудал шийдэгдчихнэ ч гэж би харахгүй л байна, яг үнэнийг хэлэхэд. Харин тэр агентлагийн даргын дэргэд байгаа зөвлөл нь тэр улсуудынхаа бүтэн төлөөллийг оруулж чадсан, тэндээсээ шийдэл юмнууд нь зөв гардаг, зөв бүтэц рүүгээ шилжиж гэмээ нь л бидэнд нэлээн тийм үйл ажиллагаа явуулахад дөхөмтэй, бас асуудлаа зөв шийдэх бололцоо боломж бүрдсэн ийм байх болов уу гэж би ингэж бодоод байх юм. Энэ талаасаа нэг хараач гэж нэг ийм зүйл хэлмээр байна.

Тэр тогтоолын өөрчлөлтийн асуудал байгаад байгаа юм. Түүнийг тэр нөхөн олгох хийгээд цаашид олгох асуудлыг тэр 9 хувь дээр л юм шиг байгаа юм. Би тэгж л ойлгоод байгаа. Хүсэлт гаргавал гэдэг үг байгаад байгаа юм. Тэгээд үүнийг бид тэртээ тэргүй бид төсвийн тодотгол дээрээ үлдсэн хүүхдүүддээ бүгдэд нь мөнгийг нь олгох хэмжээгээ бүтэн төлөвлөөд баталчхаж байгаа учраас тийм илүү үг хэрэг байна уу. Тэртээ тэргүй иргэд мөнгөө авахын

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

тулд асуудлаа тавина, ойлгомжтой. Өнөөдрийн авч байгаа хүүхдүүд яг л тийм хүсэлтээрээ л авч байгаа шүү дээ, энэ чинь угаасаа. Тэгээд тэр явдаг зарчмаараа явчихвал яасан юм бэ гэсэн ийм санал байна.

Нэг ийм хэдэн саналуудыг хэлье. Үүнийг ингэж анхаарч энэ дагасан хууль тогтоомжуудыг илүү боловсронгуй болгож, бид асуудлаа шийдэх нь зөв байх. Тэгж байж энэ ер нь төрийн алба түүнийг дагасан зардлын гүйцэтгэлийн үр дүнгийн суурилсан санхүүжилтүүд оновчтой байх эд нар бүх асуудал зөв шийдэгдэх болов уу гэж ингэж ойлгож байна. Би Сангийн яамны тэр бүтээмж дээр суурилсан нэмэгдэл давамгайлах ёстой юм гэдэг санааг би дэмжиж байгаа юм. Яг тэгж явах ёстой. Гэхдээ бид нарын төлөвлөлтөд өөрт нь но байгаад байгаа. Бид үндсэндээ албан хаагчдынхаа цалингаар тооцоолт хийгээд, цалингийн санг нь баталчхаад байгаа улсууд. Тэгвэл тэр үр дүнгийн урамшуулал гэдэг юм уу гүйцэтгэлийн үр дүн дээр суурилсан нэмэгдэл авах боломжоо энэ тэр орон зайг нь яаж цалингийн сандаа бид авч явж байх ёстой юм бэ гэдэг асуудал чинь өөрөө бас хараахан их тодорхой болчихсон зүйл биш шүү дээ. Тэгэхээр үүнийг энэ 24 оны төсөв боловсруулах явцдаа дан дамаа боловсрол, эрүүл мэнд, соёл энэ тэр гээд гүйцэтгэлийн санхүүжилтийн зарчим руу шилжчихсэн энэ байгууллагууд дээрээ нэлээн анхаарах ёстой. Гүйцэтгэлийн үр дүнгээ тооцдог журам юмнуудаа илүү боловсронгуй болгох ёстой гээд бидэнд нарийсгаж хиймээр, судалмаар, амьдралд нийцлийг нь хангамаар олон зүйлүүд байгаад байгаа. Тийм учраас нэг их судалгаа тооцоололгүй янз бүрийн тоонууд, янз бүрийн хуульд оруулаад ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүнд баярлалаа. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Энэ удаагийн тодотгол цалин, тэтгэвэр тэтгэмж

нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа. Гэтэл нөгөө гуя дагуулж хүзүү гэдэг шиг ямар ч хамааралгүй Тендерийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж ирж бас нэг үүд хаалгыг нээж байна л даа. Үүний цаана нөгөө нэг Засгийн газрын яриад байгаа төрийн байгууллагууд, хувийн хэвшилээ дэмжинэ. Хувийн хэвшлийнхний ажлыг булааж авахгүй гээд яриад байгаа энэ асуудалтай чинь хэр нийцэж байгаа юм. Тийм учраас энэ харилцааг Тендерийн хуулиар зохицуулахгүй байна гэдэг энэ заалт чинь маш том үүд хаалгыг нээж үндсэндээ энэ чиглэлийн судалгаа шинжилгээ хийдэг хувийн хэвшлийн байгууллагуудын ажлыг үндсэндээ шууд булааж авч байгаа юм, төр. Ингээд үндсэндээ тэр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийнхэн ямар ч ажил хийх бололцоо боломжгүй болж байгаа юм. Тэгээд эрдэм шинжилгээний байгууллагууд шууд худалдан авалт хийнэ гэдэг бол цаанаа асар хорттой үр дагавартай гэдгийг та бүхэн надаар илрүүлэлтгүй мэдэж байгаа. Бүх яамнууд дээр эрдэм шинжилгээ судалгааны ажил хийнэ гэдэг нэрийдлээр шууд худалдан авалтууд явах гэж байна шүү дээ. Тэгээд ерөөсөө ингээд нэг энэ Тендерийн хуулийг энэ сайд нарын нэг сонирхол нь ерөөсөө энэ нээлттэй сонгон шалгаруулалт аль болох хийхгүй байх, аль болох шууд худалдан авалт хийх, тэгээд энэ Тендерийн хуульд л янз бүрийн байдлаар энэ харилцааг зохицуулахгүй байх гэдэг заалтыг оруулах гэсэн сонирхолтой. Ингээд яваад байвал ер нь энэ Тендерийн хуульд чинь ер нь нэгмөсөн энэ хуулиа хүчингүй болгочихвол яасан юм. Бүгдийг нь тэгээд юу шууд худалдан авалтаар хийдэг л болох юм байгаа биз. Ингээд л 1, 1-ээр нь мэрсээр байгаад цаана нь ер нь үлдэхгүй болно шүү. Тийм учраас би энэ дагасан 7 хуулийн Төрийн өмчийн бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хуулийн энэ заалтыг хувь гишүүнийхээ хувиар дэмжих бололцоогүй байна. Яагаад гэхээр дөнгөж нэмэлт, өөрчлөлт хийгээд эцэслэн алх батлаагүй байж байтал ахиад араас нь залгуулаад ахиад нэмэлт, өөрчлөлт оруулж ирж байна

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

гэдэг чинь өөрөө логикийн хувьд ямар агуулга байна. Тийм учраас татчих бололцоо боломж байхгүй юм уу. Дэмжих бололцоо боломж алга л гэж хэлж байгаа юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хууль, тогтоолын төслүүдийн үзэл баримтлалтай холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа.

Ингээд төсвийн тодотголын төслийн хамт 7 хуулийн төсөл өргөн мэдүүлсэн байгаа. Ингээд хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаар санал хураалтыг явуулъя.

1 дүгээрт, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураана. Санал хураалтыг явуулъя, санал хураалт. Эхнийх нь Төрийн албаны тухай хууль. Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжин, 54,5 хувиар дэмжлээ.

2 дугаарх нь. Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжин, 63,6 хувиар дэмжигдлээ.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

54,5 хувиар 6 гишүүн дэмжлээ.

Сандаг-Очир гишүүн дэмжсэнээр протоколд тусгаж авъя.

Тэгээд 7 гишүүн болж байна гэсэн үг. 63,2 хувиар.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

11 гишүүн санал хураалтад оролцож, 6 гишүүн дэмжин, 54,5 хувиар дэмжигдлээ.

5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

6 гишүүн дэмжиж, 54,5 хувиар дэмжигдлээ.

6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг нь дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулна. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 4 гишүүн дэмжиж, 36,4 хувиар унасан байна энэ санал.

7. Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжин, 63,6 хувиар дэмжигдсэн байна.

Ингээд төсвийн тодотголын төслийн хамт Улсын Их Хурлын 2 тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн байгаа.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх санал хураалтыг явуулъя.

1. Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

2 дахь нь. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 54,5 гишүүн биш ээ, 54,5 хувиар дэмжигдлээ. 11 гишүүн оролцож 6 гишүүн дэмжсэн байна.

Сандаг-Очир гишүүн дэмжсэнээр протоколд тусгуулж байна, тийм ээ. Тэгвэл 7 гишүүн 63,6 хувиар.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баделхан гишүүн та чуулганд танилцуулна. Сандаг-Очир гишүүн тэгвэл. Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Ингээд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсэгт баярлалаа.

16.31 цаг

2 дахь асуудалдаа орёе.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээнд мэдэгдэл, 2024-25 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн бараг адилхан байгаа байх тийм ээ. Би нэмэгдсэн хүмүүсээ нэмээд танилцуулъя.

Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга. Бусад нь бүгдээрээ хэвээрээ байна.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд гишүүн хуулийн төслийн тухай зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогч асуулт асууж болно гэж заасан байгаа. Асуулттай гишүүн байна уу? Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тийм, улсын төсвийн тодотгол хийгдэж байгаатай холбогдуулж төсвийн хүрээний мэдэгдэл төсөөллөө бид нар бас өөрчилж байгаа, өөрчлөхөөс ч арга байхгүй. Угаасаа 2023 оны нийт орлого, зарлага хөдөлж байгаа учраас. Тэгэхдээ 1 зүйл байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр зэрэг тэнцлийн бодит тоон утгаараа гэсэн үг юм. Өөрчлөлт 163,8-аар өсчхөөд байгаа юм. Тэгэхээр үүнийг ер нь бодит тоон хэлбэрээр нь өсгөхгүй байх тийм бололцоо зохицуулалт хийх арга зам байна уу? Ер нь яг нарийндаа бол бид орлогын нааштай үр дүн дээр тулгуурлаж тодорхой асуудлуудаа шийдэж явж байгаа. Тийм учраас түүнийгээ дагуулаад авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний маань эцсийн үр дүн энэ тоотой бас уялдаж мессеж гараад байх тийм юу байгаад байгаа учраас би үүн дээр харин Сангийн сайдаас нэг тодорхой тодруулга авъя. Түүнээс бусад асуудлын хувьд бүрэн дэмжиж байгаа гэдгээ илэрхийлье.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Тийм боломж ер нь маш их хязгаарлагдмал, ер нь байхгүй л

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дээ. Үндсэн тэнцлээ бид нар ДНБ-ий үзлэг хувиар нь 2,6 дээрээ барьж орж байгаа. Нэрлэсэн дүнгээр бол мэдээж орон зай гарна. Түүнийг бид энэ 1 их наяд 896 тэрбум төгрөг дээр бид нар оруулж санхүүжилтээ тооцоолохгүй бол ямар ч боломж байхгүй.

Г.Тэмүүлэн: Баярлалаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 онд төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-25 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Энэ Засгийн газрын өрийн нийт хэмжээ чинь ингээд бид нар өрөө дараад бууруулаад яваад байгаа. Гэтэл 25 оны хүртэл хугацаанд ингээд харахаар яах вэ хуулиа бариад ДНБ-д эзлэх 60 хүртэлх хувьдаа хэтрүүлэхгүй байна гэдэг хуулийн заалтаа барьж байгаа боловч нөгөө талаараа өөрсдөө зээл авах орон зайгаа бий болгоод, ДНБ чинь өсөж байгаа учраас түүнд эзлэх хувь чинь өөрөө дагаж өсөөд, өр чинь өөрөө ахиад л буурахгүйгээр нэмээд л явагдаад байгаа шүү дээ. Тухайлбал эндээс харахад 25 онд гэхэд 43 тэрбум доллар болж, Засгийн газрын өр чинь 43 тэрбум их наяд төгрөг болж нэмэгдэхээр байна шүү дээ. Одоо 39 тэрбум их наяд байна. Тэгээд 1 талаас өрөө дараад ингээд бууруулаад дараад яваад байгаа гэдэг боловч нөгөө талаас ДНБ-ий өсөлт чинь өөрөө цаанаа ахиад зээл авах орон зайгаа бий болгоод хадгалаад 60 хувьдаа барцулж байгаа хуулийнхаа үйлчлэлийг хангаж байгаа гэж байгаа боловч ахиад зээл авах нөхцөл бололцоо нэмэгдээд л яваад байна. Өр чинь ерөөсөө буурахгүй харагдаад байна шүү. Үүнийг цаашидаа ер нь тэр 60 хувийг яаж бууруулмаар юм бэ дээ. Энэ 43 их наядаа яаж бууруулмаар юм бэ дээ.

Тэгээд жил ирэх тусам Засгийн газрын өр чинь нэмэгдээд л яваад байна. Нэмэгдээд л яваад байна.

Г.Тэмүүлэн: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Сандаг-Очир гишүүний асуултад тодруулъя. Төсвийн бодлого маань тэр шүү дээ Сандаг-Очир гишүүн ээ. Бид эдийн засгаа тэлэх хэрээр бидний боломжууд нэмэгдэх ёстой. ДНБ-д эзлэх алдагдлын хэмжээ, ДНБ-д эзлэх өр зээлийн хэмжээ өөрөөр хэлбэл машинаар нөгөө даац нь нэмэгдэж байгаа учраас бид нар тэр орон зайгаа бодлогын хувьд бариад л явах хэрэгтэй. Харин бид тэр орон зайгаа тултал ашиглах уу үгүй юү гэдгийг тухайн үеийн одоо, шаардлага хэрэгцээ, төсөл хөтөлбөрүүд, эдийн засгийн нөхцөл байдал, тухайн төсөл нь эргээд бидэнд үр өгөөжтэй юү, төлбөрийн тэнцэл дээр ашигтай юү гээд тэр бодлогынхоо дагуу л явна. Тухайлбал Улсын Их Хурал дээрээс батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтуудын хэмжээ маань өөрөө бараг 100 гаран их наяд төгрөг байгаа шүү дээ. Ялангуяа эндээс тэр дэд бүтцийн төслүүдийг бол бид төсөв дээр яагаад ч өөрсдөө санхүүжүүлэх ямар ч боломж байхгүй. 3 эх үүсвэр л байгаа. Засгийн газрын өөрийн зээл тусламж, гадаадын шууд хөрөнгө оруулалт эсвэл төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрүүдээр ингээд л явах юм байгаа юм.

Тэгээд нэгэнт бид нар эдийн засаг маань өсөөд боломжууд нь тэлж байгаа учраас бид нар тэр орон зайг бол бодлогын орон зай л гэж харах хэрэгтэй. Ашиглаж ч болно, ашиглахгүй ч байж болно. Одоо жишээ нь манай зээлийн үлдэгдэл бол Засгийн газрын зээлийн үлдэгдэл 52 хувьтай байгаа шүү дээ. Хязгаар нь өөрөө 60. Энэндээ хангалттай бариад явж байгаа.

Дунд хугацааны өрийн удирдлагын тухай хууль өрийн удирдлагын

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

стратегиаараа яг энэ хэмжээндээ барь, шинэ арилжааны өндөр хүүтэй, богино хугацаатай бонд гаргаж болохгүй. Энэ хөгжлийн төслүүдийгээ зөвхөн урт хугацаатай, бага хүүтэй хөгжлийн зээлүүдээр л санхүүжүүлнэ шүү гэдэг маш ойлгомжтой ийм чиглэл Засгийн газарт даалгавар болгоод өгчихсөн байгаа. Бид энэ хүрээндээ л ажиллаад явна даа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж гишүүд асуулт асуулаа.

Зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.22-т хуулийн төслийн талаар зарчмын зөрөөтэй саналын томъёолол гараагүй бол хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно гэж заасан байна. Тийм. Тэгэхээр энэ дэгийн тухай хуулийн заалтын дагуу анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг бас гаргаж байна.

Ингээд энэ горимын саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүд дэмжлээ. 63,6 хувиар дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-25 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ингээд хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Дараагийн асуудалдаа орцгооё. Ажлын хэсэгт баярлалаа.

16.40 цаг

Төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг оруулаарай. 3 дугаар асуудалтай холбогдуулж ажлын хэсгийг оруулаарай. Аудитын байгууллагынхан.

Төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат дарга танилцуулна.

Даргыг орж иртэл ажлын хэсгийг танилцуулж байя.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Доржсүрэнгийн Занданбат Монгол Улсын Ерөнхий аудитор, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, Содномцэрэнгийн Цэрэнбаяр Үндэсний аудитын газрын Тамгын дарга, Буянтогтохын Бундхорол Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор, Ядамын Самбууням Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дандарын Энхтуяа Мэдээллийн технологийн төвийн захирал, Цэрэндоржийн Баярмаа Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний газрын дарга, тэргүүлэх аудитор, Буяндэлгэрийн Баттуяа менежер гэсэн байна.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Ингээд Төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат дарга танилцуулна. 4 номер.

Д.Занданбат: Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Төрийн аудитын тухай хуулийн дагуу төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайланг нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлан бэлтгэж, үр дүнг та бүхэнд хураангуйлан танилцуулж байна.

Төрийн аудитын байгууллага хуулийн хүрээнд улс орны хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэхэд зарцуулагдаж байгаа төрийн санхүү, төсвийн үйл ажиллагаанд материаллаг өндөр эрсдэлтэй байж болохуйц төсөл, хөтөлбөр, нийгмийн хариуцлага шаардсан эдийн засгийн салбарууд, үнэн зөв хариу нэхсэн асуудлаар төрийн аудит хийж, хууль тогтоох байгууллагыг үнэн зөв мэдээллээр хангах үндсэн зорилгоо хараат бус бие даасан зарчмаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллага 2022 онд үйл ажиллагааныхаа үр нөлөөг дээшлүүлэхийн тулд цаашидын хөгжлийн төлөвшилийг эрх зүйн таатай орчин, ёс зүйн чанга хариуцлагатай хяналтын тогтолцоо, цахим дэд бүтцийг хөгжүүлэх, удирдлагын манлайлал, аудиторчуудын мэргэжлийн ур чадварыг тасралтгүй сайжруулах, аудитын чанар, үр өгөөжийг үнэн зөв бодитой тооцох бодлогын дэд зорилтуудыг дэвшүүлэн ажилласан.

Бид 2022 оны зорилтыг “аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах жил” гэж тодорхойлсон нь хянан удирдах түвшиний албан хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах, аудитын чанарын хяналтын хариуцлагыг дээшлүүлж,

улмаар эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжсэн, илүү үнэ цэнтэй, үр өгөөж болохуйц, үр нөлөөтэй тогтолцоог хөгжүүлэхэд чиглэгдсэн юм.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлсэн дүн, өгсөн зөвлөмж, чиглэлийг тусган, төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 үндсэн бүлэг, 19 зорилтын хүрээний 148 багц, арга хэмжээг төлөвлөж гүйцэтгэлийг жигд хангаж ажиллалаа.

Төрийн аудитын байгууллага 2022 онд хуульд заасны дагуу болон бодлогын хүрээнд төлөвлөсөн 4069 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, сэдэвчилсэн байдлаар гүйцэтгэл, нийцлийн 215 аудитыг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж, үр дүнг баталгаажуулан харилцагч талууд, иргэд, олон нийтэд албан ёсны цахим хуудас, нээлттэй портал сайтээр дамжуулан үр дүн тайланг бүрэн эхээр нь ил тод мэдээлэв. Тайлан дунд гүйцэтгэсэн аудитаар нийт 11,1 их наяд төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлэн 160,9 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 5,9 их наяд төгрөгийн албан шаардлагыг шалгагдагч этгээдэд өгч, үйл ажиллагааны зохион байгуулалт, санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналт, хууль тогтоомжийн нийцлийг хангуулах, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах зорилтот үр дүнд хүрч ажиллахыг үүрэгжүүлэн шалгагдагч болон хамрагдагч байгууллагын холбогдох албан тушаалтанд нийт 10235 зөвлөмж хүргүүлсэн.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 2,4 их наяд төгрөгийн алдаа илрүүлэн, аудитын явцад залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт хамгаалалт, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж, алдаа зөрчлөөс

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

урьдчилан сэргийлэх, зөвлөх чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлээ.

Тайлант хугацаанд улс орон нутгийн төсөвт 41,4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, шалгагдагч байгууллагууд 1 их наяд 244,9 тэрбум төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрсөн нь төрийн аудитын байгууллага төсвөөс авсан нэг төгрөгийн санхүүжилт тутамд 50 төгрөг 9 мөнгөний үр өгөөжийг бий болгосон бөгөөд энэхүү үр өгөөж нь төрийн байгууллагын үйл ажиллагааны ахиц дэвшил, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулах замаар улс нийгэмд үзүүлсэн ашиг тусыг илэрхийлэх үр дүнгийн чухал үзүүлэлт билээ.

Түүнчлэн тайлант онд сахилгын шийтгэл ноогдуулах 342 албан шаардлага өгч өмнөх оны үлдэгдэл 24 нийт 366 сахилгын шийтгэл ноогдуулах албан шаардлагын 331 буюу 90,4 хувь нь бүрэн хэрэгжсэн байна. Харин хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлаас бүрэн шийдвэрлэгдсэн 22, хянан шалгах ажиллагаа явуулж байгаа 85 асуудал байна.

Төрийн байгууллагуудын дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаа нь стандарт, арга зүй, дотоод аудит болон хяналт шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлага, хэрэглэгчийн зөвлөгөө, мэдээллээр хангах зэрэг чиг үүргийн хүрээнд хэрэгжиж байгаа мэт боловч хэлбэр төдий тогтвортой бус, дотоод аудитын харилцааг зохицуулсан эрх зүйн орчин бүрдээгүй, дотоод хяналтын тогтолцооны төлөвшил хангалтгүйгээс жил бүрийн аудитаар илэрч буй алдаа, зөрчил буурахгүй байна. Иймд төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж аудитын шийдвэрийн хэрэгжилтэд Улсын Их Хурал анхаарлаа хандуулан дотоод аудитын хууль, эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, төрийн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар Засгийн газарт чиглэл өгч ажиллах бодит шаардлага

байгааг анхааралдаа авахыг уламжилж байна.

Тайлант онд улсын урт хугацааны томоохон хөтөлбөр, зорилтын хэрэгжилтийг үнэлж, хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд зорилт тус бүрээр, мөн тодорхой хугацааны давтамжтайгаар гол асуудлыг эрэмбэлэн чиг үүргийнхээ дагуу улс орны хөгжилд түлхэц болохуйц тулгуур болон стратегийн хөгжлийг дэмжсэн бодлогыг баримтлан аудитыг гүйцэтгэх, чанарын хяналтын үр нөлөөг сайжруулахад ахиц гарсан жил болсон.

Төрийн аудитын байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны одоогийн гүйцэтгэлийг олон улсын шилдэг туршилагатай харьцуулан үнэлгээ хийх, төрийн аудитын цаашдын чиг хандлагыг тодорхойлох, үйл ажиллагаандаа ашиглах, мэдээллээр хангах, чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлд нэн тэргүүний зорилтуудыг тодорхойлох, ирээдүйн чадавхыг хөгжүүлэх, тогтолцоог бэхжүүлэх зорилгоор олон улсын аудитын дэд байгууллагын гүйцэтгэлийн хэмжүүрийн үзэл баримтлалын дагуу Австралийн Үндэсний Аудитын газар, Бүгд найрамдах Индонез Улсын Аудитын зөвлөлийн хамтарсан багаар гүйцэтгэлийн тогтолцоонд түншийн үнэлгээ хийлгэлээ.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх, ажлын төлөвлөгөө боловсруулан хууль, эрх зүйн орчин, дотоод засаглал, санхүүгийн удирдлага, хөрөнгө, хүний нөөц, дэмжих үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааны чанарыг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна.

Төрийн аудитын байгууллагаас 2022 онд 15 эрх зүйн баримт бичгийг шинэчлэн боловсруулж, аудитын бодлого, арга зүйг боловсронгуй болгох, аудитын

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

чанар, үр нөлөөг сайжруулах хүрээнд Аудитын дээд байгууллагын ОУБ-аас гаргасан стандарт аргачлалыг Стандартын хороогоор хэлэлцүүлэн баталж мөрдүүлээ.

Тайлант онд зохион байгуулагдсан олон улсын аудитын дээд байгууллагын 24 дүгээр Их Хурлаар өөрчлөгдөж буй орчин, шинээр гарч ирж буй эрсдэл, дэлхий нийтэд тулгарч буй сорилтыг шийдвэрлэх ач холбогдол бүхий аудитыг гүйцэтгэх замаар хариу үйлдэл үзүүлэх, аудитын үр дүнд тулгуурлан дэлхийн хэмжээнд дуу хоолойгоо хүргэх эерэг боломжуудыг хүлээн зөвшөөрч, үнэ цэнэ нэмсэн чанартай бүтээгдэхүүн гаргах хариуцлагын хүрээнд зохион байгуулалт хийж ажиллахыг улс орнуудын аудитын дээд байгууллагуудад зөвлөж байлаа.

Төрийн аудитыг чанартай гүйцэтгэж, харилцагч талууд бие биетэйгээ хамтран ажиллах зарчмуудын ач холбогдлыг баталгаажуулах, харилцагч талуудтай тогтоосон хамтын ажиллагааг үргэлжлүүлэн дэмжих чиглэлээр гаргасан тунхаглалыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын төрийн аудитын байгууллага Энто сай болон хамтын ажиллагаатай аудитын дэд байгууллагуудын сайн туршилага, харилцаа, хамтын ажиллагааг улам хөгжүүлж, тодорхой ахиц дэвшлийг гарган ажиллаж байгаа болно.

Төрийн аудитын үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхийн тулд орчин үеийн өгөгдлийн шинжилгээний шийдлүүдийг хэрэгжүүлэх, илүү үр ашигтай, үр дүнтэй аудит хийх, мэдээлэл цуглуулах, хянах үйл ажиллагааг автоматжуулах боломжийг ашиглах, мэдээллийг товч, энгийн, ойлгомжтой дүрслэлээр дамжуулан харилцагч талуудад ил тод, нээлттэй тайлагнахыг зорьж ажилласан.

Мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор орчин үеийн өгөгдлийн шинжилгээг нэвтрүүлж, системийн үйл ажиллагааг хөгжүүлэх

ажлын хүрээнд мэдээллийн технологийн дэд бүтцийн орчинд үнэлгээ хийж, дижитал мастер төлөвлөгөөг боловсруулан баталж, үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан нь төрийн аудитын байгууллагын мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгох, цогц үйлчилгээг харилцагч талуудад ил тод, иуурхай хүргэн, аудитын үр өгөөж, үнэ цэнийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны эхлэлийг тавьсан жил боллоо.

Төрийн аудитын байгууллага хуулийн хүрээнд Улсын Их Хурлын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, олон нийтийн үр ашгийн төлөө Засгийн газрын хүлээх хариуцлага, үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд туслах, олгогдсон бүрэн эрхийн хүрээнд төрийн хяналтын чиг үүргийг гүйцэтгэхдээ төрийн бүх шатны байгууллагын санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулж, төсвийн хэмнэлтийг хянах, төрийн аудитын чиглэлээр гаргасан бодлого арга зүйг улс орны төсөв, эдийн засгийн нөхцөл байдлыг үнэн зөв үнэлж, дүгнэх гол хэрэглүүр болгоход анхаарлаа хандуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн шинэчлэлт, өөрчлөлттэй холбогдуулан төсвийн үр ашигтай, зохистой удирдлагын зарчмыг хэрэгжүүлэх, түүнийг төлөвшүүлэхэд төрийн аудитын байгууллагын бүх шатын салбар нэгжийн хүлээх хариуцлага өндөр хэвээрээ байгаа бөгөөд төрийн аудитын байгууллага 2023 онд аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Түүнчлэн төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны үр дүнд тулгуурлан 2023 оны зорилтоо тодорхойлноос гадна зорилтын хүрээнд төсвийн зарцуулалтад гарч болзошгүй авлига, залилангийн эрсдэлээс урьдчилан сэргийлсэн төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд бодит

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дэмжлэг болохуйц арга хэмжээг аудит бүрийн асуудлын шинжилгээнд тусган хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байна.

Эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайланг бэлтгэн Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн бөгөөд та бүхний санал зөвлөмжийг төрийн санхүү, төсвийн хяналт аудитын цаашидын үйл ажиллагаандаа тусган ажиллах болно. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Ерөнхий аудитор Занданбат даргад баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.3-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган ирүүлснийг та бүхэнд бас тараасан байгаа.

Ингээд төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлантай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Раднаасэд гишүүн асуулт асууна.

Ш.Раднаасэд: Төрийн өмчит 197 байгууллагад компанийн санхүүгийн тайланд аудит хийсэн гээд. Энэнд чинь би итгэхгүй байгаа гэдгийг түрүүн хэлсэн. Занданбат аудитор оо. 2023 оны 3 сарын 21-ний өдөр 7/618 гэж албан бичгээр Алтай Улиастай компани өөрчлөлтгүй гэсэн дүгнэлт Наранчимэг гэж хүн чинь гарын үсэг зурсан. Яг энэ дугаар дээрээ дахиад яг энэ дугаартай бас нэг дүгнэлт гарсан нь болохоор хязгаарлалттай дүгнэлт гэж ийм байж болдог юм уу? Энэ 2 бичгийн зөрөө юу байгаа юм гэхээр албан бичгийн доод талд нэг код явдаг тийм үү? Дугаарласан цифр шифрүүд. Эхнийх нь өөрчлөлтгүй гэдэг нь 1031 гээд төгсгөлтэй, дараагийнх нь

хязгаарлалттай гэдэг нь 1116 гэсэн дүгнэлт юу тоотой. Ингээд дураараа өөрчилдөг юм уу та нар. Нэг өдөр гаргасан юмаа 3 хоногийн дотор дуудаж авчирч засаад. Тэгээд компанийн захирлыг солих ажил хийгдэж байгаа юм. Үнэхээр алдаа дутагдал гаргаад солигдож байгаа бол хамаагүй. Би тэр хүнийг ямар нэгэн байдлаар өмөөрч ерөөсөө юм дуугарахгүй. Ингээд үзэмжээрээ та нар гаргасан дүгнэлтүүдээ өөрчлөөд байх юм бол нэг даргынх нь гарын үсгээр, та нарын энэ дүгнэлтэд хэн итгэх юм бэ? Тэгээд тэр өлзий аккаунт гэнэ үү, тэр хүмүүс нь хүртэл хэлж байгаа шүү дээ. Дээрээс энэ аудитын газраас ийм шахалт өгч байгаа учраас бид нар ийм болгосон гээд. Та нар өнөөдөр их буруугүйг буруутай болгож байгаа юм чинь буруутайг буруугүй бас болгож л байгаа. Тэгэхээр энэ 197 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанид хийсэн аудит чинь бол итгэл төрөх үндэсгүй байна. Итгэл төрөх. Үүнийхээ учир начир юмыг олж тайлбарлаарай. Энэ бичиг цаас нь байгаа учраас би энэ дээр чинь ингэж бардам хэлж байгаа юм шүү. Түүнээс биш үг үсгээр ерөөсөө яриагүй. Хэчнээн хуулийн этгээдүүд дээр ийм өөрчлөлтүүд явагдаж байгаа бол. Өнөөдөр зөрчилгүй гээд гарч байгаа өөрчлөлтгүй гээд гарч байгаа энэ дүгнэлтүүдийн чинь цаана ямар юм байгаа бол. Эс үгүй бол өөрчлөлттэй гэдгийн чинь цаана өөрчлөлтгүй хүмүүс, зөрчилгүй хүмүүс ч бас байгаа юм байна шүү дээ. Ингээд өнгөрсөн жилийн чинь ажлын тайлан энэ дүгнэлт чинь ердөө 1 дүгнэхэд аягүй амар.

Их Хурлын энэ шинжилгээний албанаас асууя. Энэ нөхцөл байдал дээр та нар зүгээр цаасаар ирсэн тайлан дээр нь хийчихдэг юм уу? Энэ аж ахуйн нэгжүүд, энэ яамнууд дээр хийгдсэн юмнууд дээр үздэг юм уу? Одоо эндээс харахад бараг бүх сайд нар дээр шахуу л хязгаарлалттай гэсэн дүгнэлт явж байна шүү дээ. Энэ Тамгын газар яг ямар хэмжээндээ үзэж харж үүнийгээ хянадаг юм? Эд нараас илүү хэмжээнд тийм аудит хийж чадах уу? Бид нар хүн хүч

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дутуу байна, болохгүй байна гээд л жил болгон аудитын газрын орон тоог нэмж байгаа, цалин хөлсийг нэмж байгаа. Тэгээд Тамгын газрын энэ тайландаа харин хэр баталгаатай юм бэ, энэ чинь орж ирсэн цаасан дээр нь та нар юм бичээд ингээд зөвлөмж гээд нэг юм гаргачихдаг юм уу? Эсвэл үүний чинь цаана өөр юм байдаг. Түүнийг та нар мэдсээр байж эс үгүй бол нийлээд ингээд яваад байдаг юм уу? Энэ нэг зүйлийг тодруулъя.

2 дугаарт, танайх яг энэ гүйцэтгэлийн аудит гэдэг юмаа хийж чаддаг юм уу ер нь. Одоо энэ Төрийн албаны хууль байна. Тэр газар олголт, тэр нүүрсний хулгайтай холбоотой юмнууд дээр аудит дараа жил хийнэ гэж өмнө нь бас хийсэн л байна гэсэн. Яг хийж чаддаг юм уу? бодит нөхцөл байдал юмыг. Зүгээр хэдэн нягтлангууд суучихсан юман дээр ажиллаад байдаг юм уу? Би бол энэ чинь үр дүнгийн аудит гэж ойлгоод байгаа шүү дээ. Өнөөдөр баталчихсан энэ төрийн албаны шинэчлэл чинь хуулийн дагуу амьдрал дээр нийцэж байна уу, нийцэхгүй байна уу, эсвэл энэ чинь ийм, ийм, ийм зөрөөтэй байдлаас болоод энэ хууль чинь хэрэгжихгүй байна гээд ингээд сая төсвийн тодотголтой хамт зарим 1 тавьсан шалгууруудаа буулгая гээд оруулж ирж байх шиг л юм. Тэгээд л амьдралд хэрэгжихгүй хууль баталсны л нөлөө шүү дээ.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүнд 1 минут нэмье.

Ш.Раднаасэд: Яг өөрөө өөрийгөө яг чин үнэнээр нь Занданбал дарга аа, та нэг үнэлээдхээч. Өөрийнхөө байгууллагыг. Тэрийг чинь сонсох хэрэгтэй байна. Энэ дотор чинь би жишээлбэл зүгээр энд манай аймаг дээр тохиолдсон явдлыг мэдсэн тулдаа ингэж ярьж байгаа болохоос энд гишүүд мэдэхгүй юм зөндөө л байгаа. Тэгээд оронд нь тавьж байгаа хүмүүсийг нь хар л даа. Ямар ч мэргэжлийн бус, тийм л хүмүүс аваачаад л тавьж байна шүү дээ. Үгүй ээ, яах вэ

тавьж болно. Тэгээд сайн ажилладаг байж болно. Та нар зүв зүгээр ажиллаж байсан хүн дээр ийм дүгнэлт гаргасны төлөө энэ дүгнэлтийг нь үндэслэж хүмүүсийг ажил төрөлгүй болгож байна шүү дээ. Одоо биеэ өмөөрөх юм байхгүй. Наранчимэг ээ, чиний тэр гарын үсэгтэй 2 бичиг чинь надаа албан ёсоороо байна. Үгүй гэвэл чи цагдаад өгөөд энэ нь хуурамч, энэ нь биш гээд шалгуулаад яваарай. Ингэж дураараа гаргаж өгсөн дүгнэлтүүдийг өөрчилдөг байдал чинь танай байгууллагад итгэх итгэлийг 100 хувь алга болгож байна. Тэгээд дараа жил хийлгэх энэ захиалгат аудит гээд энэ чинь яг үнэн гарч ирэх үү гэдэгт эргэлзэхээс өөр аргагүй байдал үүсэж байна шүү дээ.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүний асуултад 4 номер Занданбат дарга. Дараагийнх нь Улсын Их Хурлын Хяналт шинжилгээний үнэлгээний газрын дарга хаана байна. Дуудаарай, хариулахад бэлдэж байгаарай. Занданбат дарга.

Д.Занданбат: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Алтай Улиастайд гарсан асуудлыг ерөнхийдөө ойлголоо. Зүгээр энэ дээр үнэхээр бас цаглаврын юу гэдэг юм төрийн өмчит байгууллагуудын ер нь бол төсөв захирагч нарын аудитыг хийж явж байх үед бас цаглаврын тэр ачааллаасаа болоод цаглавраасаа болоод ачаалал их өндөр байдаг. Алтай Улиастай дээр ийм бас ачаалал их өндөртэй байснаасаа хамаараад өмнө гарсан аудитын зөрчилгүй гэсэн дүгнэлтийг эргэж хянаж үзэж бас энэ дээр буруу дүгнэлт алдаатай дүгнэлт гарсан асуудал бас байна гэдгийг тодруулсан. Тэгээд тэр дараа нь хийсэн хязгаарлалттай байх тийм ээ? Хязгаарлалттай гэсэн дүгнэлт бол үнэхээр бодитой дүгнэлт. Тухайн үед Ганзориг гэж байсан байх захирал нь. Бас манайд асуудал тавьсан. Тэгээд тэр юман дээр нь нягталж үзэхэд бас үе шатын хяналт дээрээ бас ажлын ачааллаас болоод тодорхой хэмжээнд бас анзааргагүйгээр зөрчилгүй гэсэн дүгнэлтийг өгчихсөн байсан нь эргэж

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хянагдаад энэ тэр нь хязгаарлалттай болсон ийм байдалтай байж байгаа. Энэ тал дээр Наранчимэг дарга нь бас нэлээн дэлгэрэнгүй хариулах байх.

Нөгөө талаар бас үнэхээр бас аудитын байгууллагын нэг гол зарчим бол хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах асуудал бас байдаг юм. Тэгээд энэ олон улсын Аудитын дээд байгууллагуудын тэр холбооноосоо гаргасан ижил төстэй бусад орнуудын аудитын байгууллага 3 жил тутамд улс орнуудад түншийн үнэлгээ хийдэг. Энэ жил бид нар Австрали Индонезын багаар түншийн үнэлгээ хийсэн. Энэ түншийн үнэлгээ нь аль болохоор аудитын үйл ажиллагааг олон улсаас тавигдаж байгаа тэр стандартын дагуу хараат бусаар гүйцэтгэж чадаж байна уу, үгүй юү гэдэг дээр нэлээн том үнэлгээ өгдөг. Сая үнэлгээ хийгээд ирүүлсэн тайлан дээр энэ асуудал харьцангуй гайгүй, манай дээр бол гайгүй үнэлгээ өгөгдсөн.

Гүйцэтгэлийн аудит дээр ер нь хийж чадаж байна уу, үгүй юү гэсэн асуудлыг бас та тавьж байна. Яах вэ, зүгээр ажил сайжруулаад ажил хийгээд явж байхад алдаа оноо гаргах асуудал бас байдаг. Тэр бүх юм төгс болчихсон юм бол байхгүй. Гэхдээ аудитын өөрийнх нь нэг онцлог бий. Аудитын үйл ажиллагаа өөрөө стандартын дагуу явагддаг учраас түүн дээр нөлөөлөлд орох гэдэг юм уу хараат бусаар ажиллах тэр зарчмаа л алдахгүй бол тэр үйл ажиллагаа бол итгэж болохуйц ийм үйл ажиллагаагаар явдаг. Ер нь аудитын байгууллагын ачаалал их өндөр, хүн хүч нөөцийн хувьд их хязгаарлагдмал байгаа. Бид нар сүүлийн 2 жилд бас хүний нөөцөө Төсвийн байнгын хороогоор бас нэмэгдүүлээд ингээд бас ачааллаа харьцангуй гайгүй аваад явж байгаа. Гэхдээ энэ нь өөрөө бүрэн ишийдэгдчихсэн гэсэн асуудлууд биш.

Жил болгон аудитын сэдэв нэмэгддэг, хянаж үзэх үйл ажиллагаа бас ачаалал тэр хэмжээгээр нэмэгдэж байгаа учраас бид нар бас ачаалал нэлээн

өндөртэй л ажилладаг гэж ойлгодог. Наранчимэг дарга саяын тэр Алтай, Улиастайн чиглэлээр бас яг бодит байдал дээр бас мэдээлэл өгөх байх. Би бол товчхондоо юу гэж харж байна гэхээр нь Раднаасэд гишүүн бас мэдээлэл жаахан зөрөө байна л гэсэн бодол бас төрлөө. Тэгээд үүнийг тодруулаад ярьчихъя.

Г.Тэмүүлэн: Хэдэн номер вэ? 5 номер. Нэмэлт тайлбар.

Үндэсний аудитын газар Наранчимэг Раднаасэд гишүүний асуултад хариулья. Раднаасэд гишүүнд мэдээллийн зөрүүтэй байдлын мэдээлэл очсон байна гэж ингэж ойлгож байна. Бид Алтай Улиастай компанид 186,6 сая төгрөгийн зөрчил илэрч, аудитын тогтоосон материаллаг байдлын түвшинээс давсан учраас хязгаарлалттай гэсэн санал, дүгнэлтийг өгсөн. Төрийн аудитын тухай хуулийн 8.4-д заасны дагуу санхүүгийн тайлангийн аудитыг аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно гэснийг нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар Аудитын хуулийн этгээд гүйцэтгэсэн.

Өөрчлөлтгүй гэдэг дүгнэлтийг бид ерөөсөө өгөөгүй. Өөрчлөлтгүй гэдэг дүгнэлтийг Аудитын хуулийн этгээд нь олон дүгнэлт гарч байгаа дундуур оруулж зуруулсан нь шалгалтаар тогтоогдсон. Алтай Улиастайн компанийн Ганзориг гэдэг захирал маш олон хүнээр хязгаарлалттай дүгнэлтээ хүлээж авчхаад, өөрчлөлтгүй болгож өгөөч гэж яриулсан, хэлүүлсэн, мессеж бичсэн, хүлээж аваагүй тэр асуудлыг нь. Тэр нь бүгд нотлох баримттайгаа байгаа.

Дараагийн нэг асуудал нь энэ Алтай Улиастай компанийн хийсэн аудитын компани Ганзориг гэдэг хүн нь өөрөө Эрчим хүчний яамны ТУЗ дээр асуудлаа оруулахдаа өөрчлөлтгүй дүгнэлтийг орж хэлэлцүүлээд, өөрчлөлтгүй дүгнэлтээрээ ажлаасаа чөлөөлөгдсөн. Харин тэр ТУЗ дээр бол хуурамч дүгнэлтийг аваачиж

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хэлэлцүүлсэн. Энэ хүн манайд ямар хүсэлт тавьсан бэ гэхээр зэрэг хязгаарлалттай дүгнэлтээ өөрчлөлтгүй дүгнэлт болгож өгөөч ээ гэдэг асуудлыг хувийн шугамаар, хүмүүсээр албан тушаалтнуудаар яриулсан. Төрийн аудитын байгууллагын албан хаагчид шударга ажилладаг учраас үүнийг хүлээж аваагүй.

Дараа нь бид энэ асуудал дээр тэр хүн өөрөө хязгаарлалттай дүгнэлт авбал намайг ажлаас халах уу, энэ дээр тодорхойлолт өгөөч гэж манайд өргөдөл өгсөн. Төрийн аудитын тухай хуулиар хязгаарлалттай дүгнэлт авбал хариуцлага тооцдоггүй юм гэсэн албан тоотыг миний гарын үсэгтэй тэр захиралд өгсөн байгаа.

Дараагийн нэг асуудал нь тэр захирал өөрөө манайхыг миний өгсөн хязгаарлалттай дүгнэлт буруу байна гэдэг асуудлаар өргөдөл гаргаж шалгуулсан. Өргөдлөөр хязгаарлалттай дүгнэлт нь зөв байна гэдгийг манай бид нарыг шалгадаг манай чанарын баталгаажуулалтын газар шалгаад тогтоосон. Мөн бид нар аудитын хуулийн этгээдийн хуурамч материал өгснөөр төрийн аудитын байгууллагатай ажиллах гэрээг цуцлах буюу хууль хяналтын байгууллагаар шалгуулж байгаа. Энэ Алтай Улиастай компанийн удирдлагууд мөн хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа асуудал байгаа юм байна лээ. Үүнийг Эрчим хүчний яамнаас тодруулбал илүү мэдээллийг бас тэндээс авбал өгөх байх гэж ингэж бодож байна.

Бид нарын гаргасан хязгаарлалттай дүгнэлт бол бодитой байгаа. 3 албан шаардлага өгсөн. 87 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг хууль бус явуулсан. Авлага, өглөгөө баталгаажуулаагүй, тайлангаа хугацаанд нь гаргаж ирүүлээгүй гэсэн ийм асуудалтай байгаа. Тэгэхээр гишүүнд бас яг үнэн бодитой мэдээлэл очоогүй юм байна гэж ингэж ойлгож байна. Бүх мэдээллүүд нотлох баримттай байгаа.

Хүмүүсийнх нь бичсэн мессежнүүд байгаа, бүх асуудлууд байгаа. Бид нар энэ дээр бас шалгуулсан байгаа. Ийм мэдээллийг өгье өө гэж ингэж бодож байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн нэмж тодруулъя.

Ш.Раднаасэд: Занданбат дарга аа. Занданбат. Ачаалалтай их байсан учраас алдсан байна гээд нэг нь болохоор урдаас нь эхлээд хязгаарлалттай гэж гараад дараа нь өөрчлөлтгүй гэж гарсан гээд ингээд худлаа яриад байх юм. Та нар тоо 1031 гэдэг ширлэсэн албан бичиг чинь 1116 гэдгийнхээ өмнө явдаг юм байгаа биз дээ. Эхлээд та нар өөрчлөлтгүй гээд дүгнэлт гаргачхаад 1116 дугаар дээрээ өөрчлөлттэй хязгаарлалттай гээд доторх өгүүлбэр чинь яг ижилхэн энэ дотор нэг ч юм хөдлөөгүй. Зөвхөн гарчиг нь өөр. Наранчимэг гээд гарын үсэгтэй нь биш гэж надад байна л даа. Дотор нь нэг ч үг өгүүлбэр өөрчлөгдөөгүй, үсэг ч хөдлөөгүй. Тэгээд үүнийг биеэ өмөөрөөд ингээд байх юм. Би зүгээр хувь хүний асуудал ерөөсөө яриагүй шүү дээ, энд. Та нарын дүгнэлт хэр бодитой гардаг вэ гэдэг дээр яриад байгаа байхгүй юу.

Хууль хяналтын байгууллагаар шалгуулж байгаа юм байна лээ, ингэж байгаа юм байна лээ гэж. Тэр чинь ямар ч холбогдолгүй гэдэг бичиг цаас нь гарчихсан юм байна лээ. Тэр хувь хүний талаар хэрүүл зарга хийх гэж байгаа бол. Тэгээд ачаалал даах хэмжээнд хүмүүсээ авч ажиллуулаач. Манайх ачаалал ихтэй байдаг учраас тэр үеэр алдчихсан юм байна лээ гээд ийм утгагүй юм яриад суугаад байх юм. Тэгээд нөгөөдөх нь биеэ өмөөрөөд ингээд эхлээд өөрчлөлттэй гээд хязгаарлалттай гэж гараад дараа нь хүнээр ярьсаар байгаад өөрчлөлттэй гэж болгож зассан юм уу, өөрөө зассан байна шүү дээ, тэгвэл. Өөрийн чинь ярьсныг тэгж ойлголоо, сая. Жаал хүмүүсээр яриулж байгаад буруутайгаа буруугүй болгож засуулсан юм байна. Тэгээд ийм

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байдлаар та нар ажилд хандаж байгаа бол та нарын энэ тайланд өнөөдөр итгэх хүн хэн ч байхгүй.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Аудиторуудын бас зовлонг бас гадарлана. Зүгээр, ажлын ачаалал асар их байдаг юм байна лээ. Нэг аудитад ноогдох хяналт шалгалт тэгээд л явцын гүйцэтгэлийн гээд ингээд. Гэхдээ та бүхэн маань ингээд л жил болгон хяналт шалгалтаа хийх юм. Нөгөө гардаг зөрчил дутагдлууд нь буурахгүй яг л гардгаараа гарах юм. Харин ч бараг эсрэгээрээ өсөх жишээтэй. Тэгээд яах ёстой юм, юундаа байгаа юм, энэ хууль, эрх зүйн орчноо сайжруулах, хариуцлагын асуудал дээрээ сайжруулах ёстой юм уу? Ингээд л жил болгон байх ёстой юм шиг зөвлөмж гарч л байдаг, шаардлага гарч л байдаг, акт тавьж л байдаг ингээд л явж л байдаг, байх ёстой юм шиг гэж ойлгож байна.

Цаашидаа энэ хариуцлагын асуудлаа энэ хууль юмандаа сайжруулах, чангаруулах талаар танай байгууллагаас бодож санаж байгаа зүйл байна уу? Хуулийн төсөл юм боловсруулж байгаа юм байна уу гэдгийг 1-д асууя.

2-т, энэ Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Увс 4 аймаг хязгаарлалттай дүгнэлт авчээ. Ямар арга хэмжээ авагдсан бэ, 0,2 тэрбум буюу 200 сая төгрөгийн 6 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлжээ. Энэ ямар газрууд дээр, ямар асуудлууд үүсээд ингээд хуулийн байгууллагаар шалгуулахаар ингээд шилжүүлж байгаа юм бэ?

Нөгөө талаар өнөөдөр тодотгол хийж байна. Тодотгол хийх эх үүсвэр үндэс юунаас үүдэлтэй вэ гэхээр үндсэндээ ерөөсөө энэ төрийн авлига, хээл хахуулийн асуудлыг ил тод нээлттэй болгосноор энэ экспортын асуудлыг, үнэ ханшийн асуудлыг тодорхой болгосноор

төсвийн орлого давж байна л даа. Нөгөө талаараа үүнийг юу гэж ойлгох вэ гэхээр бас энэ хэмжээний далд эдийн засаг байгаад байна гэдгийг харуулаад байна шүү дээ, далд эдийн засаг. Тэгэхээр энэ төрийн өмчийн оролцоотой компаниуд дээр ингээд далд эдийн засаг байгаад байна. Тэгээд та бүхэн маань жил болгон хянаж шалгаад байдаг. Энэ хяналт шалгалтын хаагуур энэ далд эдийн засаг яваад байна аа? Энэ төрийн өмчийн компаниудын энэ зөрчил дутагдал, Эрдэнэс тавантолгой компани, орон нутгийн компани, үгүй ээ, энэ хяналт шалгалтын хаагуур яваад байна аа? Тэрбум битгий хэл их наядаар яригдах санхүүгийн зөрчлүүд гараад яригдаад байна шүү дээ. Хулгайн асуудлууд л байгаа шүү дээ энэ чинь.

Энэ олон 30 орчим зээлийн сангийн асуудлууд байна, сангууд. Үгүй ээ, эхнийх нь ингээд тодорхой болоод ирэхээр энэ Боловсролын зээлийн сангийн хаагуур нь энэ аудит явсан юм бэ, хаагуур нь явсан юм? Энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, нийгмийн даатгалын сан, ТЭДС үгүй ээ тэгээд маш олон сангууд байгаа. Тэгээд энэ болгоны хаагуур нь та бүхний дүгнэлт гарчхаад, өнөөдрийг хүртэл явж ирсэн юм бэ? Цахим хөгжлийн яам бий болсноор 5 Ш ажиллагааны хүрээнд өнөөдөр энэ сангуудын зарцуулалт тодорхой болж байна. Тэгэхээр та бүхэн маань яг хуулийн дагуу энэ хяналт шалгалтын ажлууд явж байна гэж ойлгоход бас учир дутагдалтай байгаа юм биш үү? Энэ дээр та бүхэн юу гэж үзэж байгаа вэ? Энэ сангуудын талаар.

Нөгөө талаар та бүхэн ингээд шаардлага, зөвлөмж хүргүүлж байна. Шаардлага, зөвлөмжийн чинь хэрэгжилт 50 хүрэхгүй хувьтай байна шүү дээ. Хэн хэрэгжүүлдэггүй юм. Аудитын байгууллагаас тавьсан зөвлөмж, шаардлагын биелэлт дөчин хоёрхон хувьтай энэ нь бүр өнгөрсөн оныхоос 12 хувиар буурсан үзүүлэлттэй харагдаж байна. Үгүй ээ, ингээд үзэхээр та бүхэн шаардлага тавьдаг, алдаа зөрчлөө арилга

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

гэхээр түүнийг чинь биелүүлдэг хүн 2 хүний нэг нь биелүүлэхгүй байна гэсэн үг шүү дээ. Тэгээд ингээд явах юм уу? Тэгэхээр энд чинь цаашидаа хариуцлагын асуудлаа чангаруулах асуудал яригдаад байгаа биз, харагдаад байгаа биз. Энэ дээр та бүхэн ер нь юу гэж бодож байна? Ийм асуултуудад хариулж өгөөч.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. 4 номер.

Д.Занданбат: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Зөрчил буурахгүй байна. Яах вэ гэсэн ерөнхий агуулга бас яригдаж байна. Энэ харьцангуй ойлголт. Өнгөрсөн 22 онд бид нар бас нэг, мэдээж хууль, эрх зүйн орчин өөрөө өөр байсан. Үйл ажиллагааны зохион байгуулалт эд нар дээр бас тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг бид нар хийсэн. Харьцангуй л ойлголт юм л даа.

Зөрчил илрүүлж гаргаж ирж байгаа нь нэг талдаа ерөнхийдөө зөрчил буурахгүй байна. Тэр талаасаа харвал бас сайн ажиллаж байна уу, үгүй юү гэдэг юмыг бас нэг талдаа асуух байх. Нөгөө талдаа илрүүлэлтийг сайн хийж байна бол гэдэг бол бас ажил муу гэсэн үг бас биш байх.

Ер нь аудитын өнөөдөр байж байгаа эрх зүйн орчин нь хуулийнхаа хүрээнд л төрийн байгууллага үйл ажиллагаагаа явуулна. Аудит өөрөө шийдвэрээ гаргадаг, дүгнэлт гаргадаг хамгийн гол асуудал, тэгээд зөвлөмж өгдөг. Зөвлөмжийн биелэлтийг үндсэндээ 6-9 сартай зарим нэг газар бол жилийн хугацаатайгаар зөвлөмж өгдөг. Энэ нь он дамжиж, өөрөөр хэлбэл 23 он руу дамнаж бас зөрчлийн зарим нэгэн биелэлтүүд эд нар орж ирэх болохоор зэрэг 22 оныхоо тайланд эд нар орохгүй асуудлууд бас байдаг. Тэгэхээрээ зэрэг хууль, эрх зүйн орчноо аудитын үндсэн мөн чанар зөвлөж, ажлыг сайжруулахтай холбоотой зөвлөмж өгч явж байгаа энэ асуудал нь өнөөдрийнхөө

энэ олон улсынхаа стандартаар л тодорхойлогдож байгаа юм. Хэрвээ хариуцлага тооцоод тодорхой хэмжээнд хариуцлага тооцдог ийм эрх зүйн санкцтай болоод ирэх юм бол энэ чухам хууль тогтоогчдын л бас шийдэх ёстой асуудал байх.

Бид нар Улсын Их Хурлын дарга манай дээр очиж бас хяналт шалгалтын ажлыг сайжруулахтай холбоотой зөвлөмж чиглэлийг өгсөн. Энэ хүрээнд дээрээ бид нар хууль, эрх зүйн шинэтгэл хийх ажлыг сайжруулахтай холбоотой эрх зүйн орчны судалгаа хийж явж байгаа. Үүгээрээ аудитын төрийн хяналтын байгууллагын тогтолцоо янз янзын л байдаг. Хэрвээ өөрсдөө асуудлаа зөрчлөө гаргаж ирээд түүнийг нь шийдвэрлээд явна гэх юм бол шүүхийн шинж чанартай тийм тогтолцоо бас бусад орнуудад бас байдаг тийм тогтолцоог бас сонгож болно.

Өөр чинь юу байсан бэ? Энэ далд эдийн засагтай аудитын байгууллага яаж тэмцэх ёстой вэ гэж. Ер нь бид нарын нэн ялангуяа Улсын Их Хурлын дэргэдэх байгууллагууд, АТГ-тай, прокурортой хамтарч ажиллаж байгаа. Бид нар мэдээллээ солилцож байгаа. Сүүлийн үед Ерөнхий прокурор луу бас хууль хяналтын байгуулалд өгч шалгуулах асуудлууд нэлээдгүй их гарч ирж байгаа.

Дээрээс нь зохион байгуулалтынхаа хувьд бид нар залилангийн горимыг стандартыг бас нэлээн харж тэр тал дээрээ нэлээн сургалт явуулж, тэр тал руу чиглэсэн зохион байгуулалтыг бас хийж явж байгаа. Энэ нь 23 оны үйл ажиллагаанаас нэлээн тод харагдах байх.

Олон сангууд дээр нэг ийм юм байгаа юм л даа Сандаг-Очир гишүүн ээ. Санхүүгийн аудитаар бид нар тодорхой цаглавар хугацаанд тэр баланс дээр байж байгаа тоог л бодитой байна уу, үгүй юү гэдгийг л батлах тийм л чиг стандарттай. Таны яриад байгаа тэр

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хулгай эд нарыг бол тусгайлсан сэдэв авч өөрөөр хэлбэл Төсвийн байнгын хорооноос өгөгдсөн сэдвийн хүрээн дээр нь нийцэл болон гүйцэтгэлийн аудитыг ил хийж байж байж түүгээр илүү тодорхой үр дүнтэй байна, ийм ийм хууль дүрмээ зөрчсөн байна, ийм ийм залилангуудын шинж чанар байна гэдэг юмнууд нь илүү тодорхой гарч ирдэг. Ийм л үйл ажиллагааны горимтой юм байна лээ.

Г.Тэмүүлэн: 5 номер нэмж тайлбар, хариулт өгье.

Ц.Наранчимэг: Сандаг-Очир гишүүний асуултад нэмэлт тайлбар, тодруулга өгье гэж ингэж бодож байна. Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд жил бүр санхүүгийн тайлангийн аудит хийдэг. Санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын тусгай сангуудад хязгаарлалттай дүгнэлт өгч байсан буюу Хөдөө аж ахуйг дэмжих сан дээр 2 жил дараалж сөрөг дүгнэлтийг өгсөн. Сөрөг дүгнэлт өгнө өө гэдэг бол энэ сангийн үйл ажиллагаа маш их доголдолтой сан. Цаашаа явахад эрсдэл маш өндөр байна гэсэн ийм дүгнэлт байгаа. Аудит хийхэд ямар нэгэн байдлаар нотлох баримтыг авч чадахгүй байна гээд 20, 21 онд татгалзаад энэ жил ХАА-г дэмжих сан дээр сөрөг дүгнэлт өгсөн.

Боловсролын зээлийн сан болон бусад сангууд дээр хязгаарлалттай дүгнэлт өгч энэ байгаа авлагууд тооцоо нийлж баталгаажуулахгүй одоо авлагууд маш өндөр хэмжээний авлагууд байна. Үүнийгээ баталгаажуулах зайлиггүй шаардлагатай байна. Мөн Боловсролын зээлийн сан дээр шаардлага хангахгүй хүмүүс суралцаж байна гэдэг дээр төлбөрийн акт тогтоож байсан, албан шаардлага өгч байсан. Ноднингийн өнгөрсөн оны Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан дээр Засгийн газарт төрийн аудитын байгууллага энэ сангуудын арга хэмжээг Засгийн газар дээрээ анхаарч ажиллахгүй сангууд болохгүй байна. Энэ дээр анхаарч ажилла.

Засгийн газрын түвшинд тодорхой арга хэмжээ ав гэсэн ийм зөвлөмжийг өгсөн.

Мөн Боловсролын зээлийн сангийн мэдээллүүдийг саяын завсрын аудитаар төрийн аудитын байгууллага үүнийгээ ил мэдээллээ гэсэн албан шаардлага өгүүлээд ил мэдээлүүлэх ийм арга хэмжээнүүдийг аваад явж байгаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн компаниудын аудитыг эрсдэлтэй байна гээд гүйцэтгэлийн аудит хийсэн. Энэ дээр засаглалыг нь сайжруулахгүй бол энэ төрийн болон орон нутгийн өмчит компаниуд болохгүй байна гэсэн ийм дүгнэлтийг гаргаж гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүлсэн.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагч нарын ялангуяа хязгаарлалттай дүгнэлт аваад байгаа төсвийн ерөнхийлөн захирагчдын аудитын дүгнэлтийг харьяалагдах Байнгын хороогоор нь хэлэлцэж тухайн чиглэлүүдийг өгч бай гэсэн ийм зөвлөмжийг бас хүргүүлсэн.

Дараагийнх нь асуудал нь бид одоо энэ тайлангаар төрийн аудитын байгууллагаас өгч байгаа зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт дээр хэрэгжилтийн хувь дээр анхаарч энэ жилийг Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилт, ил тод байдал, үр өгөөжийг сайжруулах жил болгож зарлаад бид энэ жилийн ажлын хүрээнд төрийн аудитын байгууллагаас өгсөн энэ асуудал дээрээ бас дүгнэлт хийж ажиллах ийм арга хэмжээнүүдийг авч байгаа.

Ер нь бол аудитын байгууллагад ажиллаж байгаа бид бүхэн ямар дүгнэлт хийдэг вэ гэхээр аудитын байгууллагаас гаргасан тайланг иж бүрнээр нь унших юм бол маш их асуудал байна. Аудитын байгууллагын тайлантай шат шатын байгууллагын дарга нар уншиж танилцахгүй байна. Зөвхөн санхүүгийн ажилтны ажил мэт байгаад байгаа нь

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

энэ гаргаад байгаа энэ аудиторуудын маш их гаргаж байгаа зүйл маань үр дүнгүй болоод байгаа энэ асуудал бол төрийн аудитын байгууллагаас биш, нөгөө шалгагдагч этгээдүүд буюу аудит хийж байгаа байгууллагуудын удирдлага, дарга нар эд нарт энэ тайлантай маш сайн танилцаж байвал илүү үр дүнтэй болно гэж ингэж үзэж байгаа.

Гүйцэтгэлийн аудитаар бол бид нар Төсвийн байнгын хорооноос батлаад өгсөн сэдвийн хүрээнд маш том том аудитыг хийсэн, үр дүнтэй дүгнэлтүүдийг гаргасан.

Санхүүгийн тайлангийн аудитаар гүйцэтгэлийн аудит хийх зайлшгүй шаардлага байна гэдгийг дараагийн аудит хэсэг дээр тайланд бичдэг. Үүгээр Эрдэнэс тавантолгой дээр гүйцэтгэлийн аудит хийгээд тайланг нь хүргүүлчихсэн. Бас компаниуд дээр гүйцэтгэлийн аудит хийх зайлшгүй шаардлага байна. Сангууд дээр гээд сангууд дээр бас гүйцэтгэлийн аудит хийгээд тайлангуудыг нь хүргүүлээд Монгол Улсын Ерөнхий аудитор дотооддоо үндэсний стандарттай болсон, дүрэм журмаа шинэчилсэн. Бид программтай болсон, ямар нэгэн аудитыг бүгдийг нь программаар хийж байна. Сургалтын систем ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж тайлбар өгөх үү? 1 номер.

Сандаг-Очир гишүүний асуултад нэмж тодруулга хийе. Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын дарга Энхболд. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах тал дээр эрх зүйн ямар зохицуулалтууд санаа байна вэ гэдэг ийм асуулт асуусан. Тэгэхээр бид нар зөвлөмжийн хэрэгжилт аудитын төрлөөрөө 2 янз байгаа юм. Санхүүгийн аудитын хувьд бол маш богино хугацаанд хэрэгжүүлэх боломжтой зөвлөмжүүд байдаг учраас хэрэгжилтийн хувь өндөр гарах магадлалтай байдаг.

Гүйцэтгэлийн аудитаар бол тогтоцоог нь өөрчлөх эсвэл эрх зүйн зохицуулалтыг сайжруулах асуудлууд байдаг учраас 2, 3 жилд дамнаж бас гарах ийм хэрэгжилт нь бол байх нөхцөл бүрддэг. Энэ дээр 2, 3 үр дүнтэй боломжууд байна гэж харж байгаа.

1-д нь, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт өөрчлөлт оруулах тухай хууль дээр бид нар саналаа өгсөн байгаа. Шалгагдагч байгууллагууд зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг ажлын төлөвлөгөөгөө хугацаатай гаргаж ирээд энэ хугацаандаа төлөвлөгөө гаргаж өгөөгүй бол хариуцлага тооцдог.

2 дугаарт, хугацаанд төлөвлөгөөнийх нь хэрэгжилтийг Байнгын хороо дээр авч хэлэлцэж хариуцлага ярьдаг ийм нэг үр дүнтэй механизм байгаа. Үүнийг бол бид нар эрх зүйн зохицуулалтыг нь хийхээр нэмэлт тодруулга дээр явж байгаа учраас гишүүд та бүхэн маань бас дэмжиж өгөөсэй гэж бодож байна.

2-т нь, үр дүнтэй арга бол Улсын Их Хуралтай хамтын ажиллагааны үр дүн байгаа. Энэ дээр бид нар сая өнгөрсөн 2 жилд нэлээн хэдэн гүйцэтгэлийн аудитын үр дүнгээр хяналтын түр хороо дээр хамтарч ажилласан байгаа. Тухайлбал, Төрөөс эмийн талаар баримтлах бодлого, хүнсний аюулгүй байдлыг хангах бодлого, Хөгжлийн банкны асуудлууд дээр хяналтын түр хороо байгуулж ажиллаад үүний аудитын зөвлөмжийг илүү хяналтын түр хороогоор нарийвчилж авч үзэж явж байгаа нь нөгөө хариуцлага, сахилга батыг сайжруулахад үр дүнгээ өгсөн гэж үзэж байгаа.

3 дахь асуудал нь Төсвийн байнгын хороо дээр аудитын зөвлөмжийг асуудлыг хариуцсан тусгайлсан референт, зөвлөлтэй байгаад түүн дээр аудитын байгууллагатай зөвлөмжүүдийг зайлшгүй хэрэгжүүлэх зөвлөмжийн жагсаалтыг гаргаж шийдвэр гаргуулдаг

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ийм тогтолцоог хэрэгжүүлж байж бас бид нар энд төрийн аудитын байгууллага Улсын Их Хурал болон бусад хяналтын байгууллагуудтай хамтарч ажиллаж байж зөвлөмжийн хэрэгжилтийн үр дүн сайжруулах ийм боломжууд байгаа.

Зээлийн тусгай сантай холбоотойгоор Боловсролын сангийн зээлийн асуудлыг аудитын байгууллага гаргаж тавьсан. Аудитын байгууллагын гаргаж ирсэн актууд дээр энэ сошиалаар яваад байгаа мэдээллүүд үр дүнгээ өгч байна гэж үзэж байгаа. Опен аудит цэг мн дээр бүх аудитын тайлангууд тавигдсан. Тэгэхээр энэ дээр бас аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд маань ашиглаж сурч байгаа, аудитын байгууллагын ил тод байдал хангагдаж байгаа нь бас энэ үзүүлэлтээр хэмжигдэх боломжтой юм гэж бас нэмж тодруулж хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа.

Тайлантай холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа.

Тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Байна. Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр аудитын тайлан орж ирж байна. Мэдээж манай энэ аудитын байгууллага бол олон жил энэ үйл ажиллагаа явуулаад энэ дотоод стандартууд юмнууд нь шинэчлэгдээд бас ажил нь нэлээн тийм төлөвшчихсэн. Гэхдээ бидэнд анхаармаар зүйлүүд бас байгаад байх шиг байгаа юм. Энэ Их Хуралтай хамтарч ажиллах ажиллагаа талдаа илүү анхаарах ёстой юм уу. Ер нь энэ хяналт шалгалтын байгууллагуудын хийж байгаа үйл ажиллагаа эргээд эрх зүйн орчныг боловсронгуй болгох аливаа хийдэгдэл, асуудлуудыг арилгах чиглэл рүүгээ илүү явбал үр өгөөж нь цаашидаа илүү үр дүнтэй байх ёстой л гэж ингэж л харагдаад байдаг. Тийм учраас энэ

талаасаа асуудалдаа хандах ёстой болов уу гэсэн нэг ийм зүйл байна.

2 дахь зүйл. Энэ төрийн өмчтэй байгууллагууд дээр бид аудит хийж байгаа. Тайланг нь ч хийж байгаа, гүйцэтгэлийг нь ч хийж байгаа. Тэгэхээр Их Хурал дээр энэ төрийн өмчтэй аж ахуйн байгууллагуудын мэдээлэл нэлээн тийм багц дүнгээрээ орж ирнэ үү гэхээс биш задаргаа хэлбэрээрээ орж ирдэггүй. Тийм учраас тэнд асуудал яаж явж байна гэдэг мэдээлэл юмнуудыг манай аудитын байгууллага нэлээн сайн анзаарч, тэгээд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар холбогдох байгууллагуудад их тодорхой чиглэл өгдөг. Зарим дүгнэлт, зөвлөмжүүд нь энэ Их Хурал руугаа орж ирдэг байх хэлбэрээрээ л явах ёстой болов уу гэж би бодоод байдаг. Жишээ нь, Эрдэнэс тавантолгой өөрт ямар ч хамааралгүй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээд яваад байдаг. Багануурын нүүрсний уурхайн өвлийн бэлтгэлийг хангах ч гэх шиг. Шивээ овоогийн уурхайн өвөлжилтийн бэлтгэлийг хангана ч гэх шиг. Эрдэнэт жорлон барина ч гэх шиг. Ингээд сонин сонин юм уг нь хуульд байхгүй шүү дээ. Төрийн өмчөөс ямарваа нэгэн байдлаар хөрөнгө гаргах тийм асуудал байхгүй. Засгийн газар гэдэг юм уу Их Хурал асуудал ярих гэж байгаа бол өөрийнхөө төсөвт төвлөрүүлсэн орлогоосоо дахин хуваарилалтын зарчмаар л гаргах ёстой. Түүнийгээ бид нэг төсөвтэй байх тухай асуудал гэж ярьдаг. Гэтэл өнөөдөр яг нарийндаа авч үзэх юм бол хэчнээн ч төсөвтэй болчихоод байгаа юм. Тэгээд үүнийг бол энэ аудитын байгууллага цэгцлэх тал дээр нь онцгой анхаарч, мөн эрх зүйн орчин тал дээр нь ямар зүйлд зохицуулалт дутчихаад ийм асуудал үүсээд байна гэдэг юмыг зөв болгох тал дээр нь нэлээн анхаарал төвлөрүүлж өгөх ёстой болов уу гэж.

3 дахь хэлмээр байгаа зүйл. Чадамжийн тухай л ойлголт юм. Энэ төрийн өмчтэй компаниуд чинь гэдэг юм уу энэ том хөгжлийн төслүүд чинь аудит ярихаараа олон улсын нэр хүндтэй

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

аудитын тухай яриад байх юм байна шүү дээ. Үгүй ээ, тэр чинь дагаад хөөрхөн мөнгө гардаг биз дээ. Тэгэхээр зэрэг яагаад энэ үндэсний аудитын байгууллагуудын имиж чадамж өсөхгүй байна. Манай өөрийн энэ аудитын байгууллага ч гэсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдөлт, түүгээр үнэлэгддэг үнэлгээ их өндөр байх ёстой.

Дээр нь тэр хувийн хэвилийн аудитын байгууллагуудаа өсгөж бойжуулах чиглэл дээр нэгэнт бид нарын үйл ажиллагаа нэг учраас тэр нөхдүүдийг зөвлөмж чиглэлээр хангаж бас тодорхой төрийн зарим байгууллагууд дээр та нар гэрээний үндсэн дээр аудит хийлгээд байгаа, тэр байгууллагуудаар. Тэр нөхдийн үйл ажиллагаанд тавьдаг хяналтыг сайжруулах замаар энэ үндэсний аудитын байгууллагуудын чадамж, имижийг өсгөх замаар бид бас нэг жоохон гадагшаа чиглэсэн урсгалыг бууруулах л ийм л арга хэмжээ байх гээд байх шиг байгаа юм. Магад ч үгүй, энэ хэрвээ их сайн явж олон улсад хүлээн зөвшөөрөгдөж чадах юм бол бүс нутгийн аудитын үйл ажиллагаа руу орох ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Тайлантай холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа.

Ингээд Төрийн аудитын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны тайланг сонсож дууслаа.

17.32 цаг

Дараагийн асуудалдаа орцгооё.

“Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэх ажлын сэдэв батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Сэдвийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна. Ажлын хэсэг түрүүн танилцуулснаар хэвээр байгаа. Занданбат дарга.

Д.Занданбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төслийг боловсруулан Төсвийн байнгын хороонд хүргүүлж та бүхэнд танилцуулж байна.

Төрийн аудитын байгууллагын Монгол Улсын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хүрээнд болон бодлогоор гүйцэтгэх 33 аудитын сэдвийг судалж бэлтгэн тэдгээрээс хуульд заасны дагуу хийх 28, бодлогоор гүйцэтгэх аудитын 5 сэдэв байна.

Төрийн аудитын байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаварт хугацаа буюу 2024 оны 01 дүгээр сарын 25-аас 06 дугаар сарын 15-ны хооронд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон улс орон нутгийн төсөвт байгууллага, сан, төсөл хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлнэ.

Мөн Газрын тосны тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд газрын тосны өртөг нөхөх зардлыг баталгаажуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, улсын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн зэрэг сэдвээр гүйцэтгэл нийцлийн аудит хэрэгжүүлэхээр боловсруулав.

Монгол Улсын Их Хурлын болон орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох, намуудад иргэд,

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг баталгаажуулах, улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах болон сонгуулийн зардлын тайланг хянаж, үр дүнг олон нийтэд мэдээлэх, түүнчлэн улс, орон нутгийн ээлжит сонгуульд төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хуульд заасан цаглаварт хугацаанд аудитыг гүйцэтгэхээр төлөвлөлөө.

Төсөлд хүргүүлсэн аудитын сэдвээс гадна Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-д заасны дагуу орон нутаг дахь Төрийн аудитын газар тухайн орон нутагтаа 4-өөс доошгүй аудитын сэдвийг бодлогоор төлөвлөж гүйцэтгэх болно.

Эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын байгууллагаас 2024 онд гүйцэтгэх аудитын сэдвийг хуульд заасны дагуу бэлтгэн хүргүүлсэн төслийг Төсвийн байнгын хороогоор хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Занданбат даргад баярлалаа.

Аудитын сэдэвтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Аудитын сэдэвтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? 2 гишүүн байна. Батжаргал гишүүнээр тасалъя. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Энэ аудитын сэдэв дээр Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн ерөнхий газрууд дээр аудит оруулах саналыг нэмж оруулж байна. Ийм санал гаргаж байна.

Г.Тэмүүлэн: Санал гаргаж байна. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тийм ээ, тэр газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, үр дүнгийн асуудлыг

бид нэлээн сайн судалмаар байгаа юм. Нэг том үйлдвэр хэдүүлээ бариад л байгаа гээд байдаг. Гэтэл өнөө газрын тос олборлож байгаа аж ахуйн байгууллагууд нь жилээс жилд олборлолтоо бууруулаад байдаг, нөөц тогтоолтын ажил тодорхой одоо юу гэдэг юм бэ дээ, үр дүнтэй гэдэг юм уу баталгаажсан нөөц нэмэгдчихгүй яваад байдаг. Тэгээд хэдүүлээ энэ чинь нэг том үйлдвэр барьчаад гаднаас баахан түүхий тос авчирч байж, боловсруулалт хийдэг юм руу орох вэ дээ. Тэгэхээр зэрэг энэ дээр нэг нэлээн тийм аудитынхаа удирдамж юмыг нэлээн нарийсгаж гаргаж, энд нэг нэлээн тийм цогц байдлаар нь асуудалд хармаар. Тэгээд ер нь энэ өнгөрсөн хугацаанд Бүтээгдэхүүн хуваах гэрээний үр өгөөжөөр ер нь юу орж ирсэн юм бэ, Монголд. Сая өнгөрсөн 2 жил энэ нефть бүтээгдэхүүний үнэ өслөө, түүхий нефтийг гадагш нь гаргаад байна. Энэ дээр чинь үнийн өсөлт үүссэн байлгүй дээ. Түүгээр Монгол руу орж ирсэн мөнгөнөөс нь буцаагаад импортынхоо шатахууны үнийг тогтворжуулахад зарцуулъя л даа гэхээр зэрэг олигтой юм орж ирээгүй гээд ингээд суугаад болж өгөхгүй байгаа юм, яг үнэнийг хэлэхэд. Тэгэхээр үүнийг нэг тийм цогцоор нь харах асуудал дээр би аудитын байгууллагыг илүү төлөвлөгөө юмандаа нарийсгаж хараач ээ гэж. 1 ийм санал байна.

2 дахь зүйл болдог юм уу үгүй юм уу. Би бол их бүдүүлэг л юм ярих гээд байна. Энэ төрийн болон орон нутгийн өмчийн асуудал, энэ төрийн болон орон нутгийн өмч дээр тулгуурласан компанийн асуудлыг эрх зүйн хувьд нь энэ амьдрал, үйл ажиллагаандаа хэр нийцэж байгаа юм бэ гэдэг юмаа харж, энэ хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох тал дээр аудитын байгууллага нэг жосоохон олон жилийн шалгалтын чинь үр дүн энэ дээр тулгуурласан та хэд дээр их бодитой, бодлогын шинжилгээ зураглал гарчихсан байх ёстой л гэж хараад байна л даа. Үүн дээрээ тулгуурлаад тийм тов тодорхой санал, дүгнэлтийг энэ Байнгын хороо руу оруулж ирээч. Тэгэх юм бол бид

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

энэ явж байгаа хууль тогтоомжууд дээр хийдэл багатай тэгээд энэ Монголд гэдэг юм уу, Монголын ард түмэнд эрх ашигт нь нийцсэн тийм эрх зүйн зохицуулалт гаргачих бололцоо байгаад байх юм.

Г.Тэмүүлэн: Сая гишүүд тодорхой 2024 оны гүйцэтгэх аудитын сэдэвт тусгуулах саналуудын талаар бас хэллээ. Үүнтэй холбогдуулаад Ерөнхий аудитор Занданбат дарга та тайлбар өгөх үү? Яг саяын гишүүдийн гаргасан саналыг, гишүүдийн гаргасан саналыг тусгах боломж бололцоо байна уу? Занданбат дарга 4.

Д.Занданбат: Тийм, яах вэ, зүгээр Сандаг-Очир гишүүн бол нийгмийн даатгал, халамжийн чиглэлээр аудитын сэдэв өгч байна гэж ойлгосон. Ер нь аудитын сэдвийг гүйцэтгэхтэй холбоотойгоор бэлтгэл ажил гэж байдаг, судалгаа хийдэг. Бид нар судалгаа, тооцоо, хүн хүч, эд нартаа бүх юман дээрээ тооцоогоо хийгээд саяын сэдвүүдийг оруулж ирсэн.

Нийгмийн даатгал, халамжийн чиглэлээр хийгдэх аудит бол жишжиг аудит биш нэлээн том аудит. Түүн дээр сүүлийн үед нийгэмд гарч байгаа шүүмжлэл бол залилангийн шинж чанартай, халамжийн сан бас их зүй бус зарцуулагдаж байгаа. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт бас залилан их байгаа гэсэн иймэрхүү юунууд нэлээн байгаа. Өөрөөр хэлбэл харахад нэг чиглэлийн юм шиг боловч их өргөн хүрээн дээр ажиллах ийм зайлиггүй шаардлага байгаа учраас бид нарт хүн хүч, нөөцийн хувьд бас эргэж харах судалгаа хийх ийм зайлиггүй шаардлага байгаа. Тэгээд ирэх он маань өөрөө сонгуулийн жил, сонгуулийн жил учраас яах аргагүй, сонгууль тойрсон Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгууль тойрсон хуулиар зайлиггүй хийгдэх маш олон мөрийн хөтөлбөрөөс өгсүүлээд зардлын тайлан хүртэлх маш олон зүйлүүд байдаг. Тэгэхээрээ энэ бол нэлээн том хэмжээний аудит байгаа юм.

Хэрвээ энэ нийгмийн даатгал, халамжийн аудитыг нь бид нар дотроо аудитынхаа сэдвийг хасаж байж байж энэ рүүгээ оруулах хүн хүчний нөөцийн боломж байгаа. Тэгж зохицуулах хэрэгтэй болов уу гэж санаж байна.

Тэр газрын тосны зүйл дээр бол бид улсын төсвөөс санхүүжүүлж байгаа геологийн нөөц тогтоох сэдвээр 24 онд байгаа, Батжаргал гишүүн түүнийг бас мэдэж байгаа байх. Тэрийгээ нэлээн нарийвчлаад энэ газрын тосны бүтээгдэхүүн хуваах, түүний өгөөж, үр дүн, зохистой байдлыг харуулах, гүйцэтгэл нийцлийн энэ юмыг жаахан нарийвчилж сэдэв рүүгээ хараач ээ гэсэн санаа хэллээ гэж би ойлгосон. Үүнийг харин, үүнийг тэр чиглэл рүү нь хийгээд явчихад шинээр асуудал гарах нь харьцангуй гайгүй байх.

Төрийн өмчит үйлдвэрийн газар дээр эрх зүйн одоо нэн ялангуяа засаглал талын зохицуулалтыг сайжруулах эрх зүйн талын бас судалгаа, дүн шинжилгээ хийгээч ээ гэсэн санал тавьж байна гэж харж байна. Өнгөрсөн онд, үгүй ээ, сая бид нар төрийн өмчийн төрийн болон орон нутгийн өмчит компаниуд хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үр ашиг дээр аудит хийсэн. Энэ дээр нэлээдгүй бас асуудлууд гарсан. Таны тэр ярьж байгаа нэн ялангуяа засаглалтай холбоотой. Төрийн өмчит үйлдвэрийн аж ахуйн газруудыг үр ашигтай байлгах талын дүн шинжилгээг энэ тайлантай холбогдуулаад бид нар бас хараад эрх зүйн ийм ийм зохицуулалт байна гэдэг саналыг Байнгын дороо руу хүргүүлэх тэр тал дээрээ анхаараад ажиллачихад бололцоотой, ер нь бол материал байгаа гэж ойлгож байгаа. Энэ бол аудитын сэдэв биш зүгээр эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой. Энэ дээр боломжтой гэж харж байна.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр Батжаргал гишүүний саналыг ерөөсөө байгаа дээр нь нэмж тусгаад, өөрчлөн найруулаад ингээд оруулах боломжтой юм гэж

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ойлголоо. Тэгэхээр тэр та бүхэн томъёоллоо бас хийгээрэй. Сандаг-Очир гишүүнийхийг бол хасаж байж заавал ч үгүй гүйцэтгэх боломжтой гэсэн саналыг хэлж байна шүү дээ, Занданбат дарга.

Тэгэхээр та бүхэн өөрсдөө сая энэ хүргүүлсэн аудитын сэдэв дээр чинь нийтдээ 33 ажил хийсэн байна. Эхний 28 нь хуулийнхаа хүрээнд заавал ч үгүй гүйцэтгэгдэх ёстой ажлууд байгаад байна. Сүүлийн 5 нь 29-өөс 33-ын хооронд бодлогоор гүйцэтгэх аудитын сэдэв гэсэн байна. Тэгэхээр эндээс энэ 5 ажлаасаа та хэд өөрсдөө аль ажлыг нь хасаад саяынхыг нэмж оруулах гэдэг саналаа хэлэх хэрэгтэй байна. Тэгээд түүгээр нь батлаад ингээд явчихъя.

4 номер.

Д.Занданбат: Яах вэ, зүгээр сан талаасаа ярих юм бол Ирээдүй өв сангийн тухай хуулийн хэрэгжилт, сангийн хөрөнгийг удирдах үйл ажиллагаа, үр дүн, нөлөө гэсэн аудит байна. Энэ бол нийгмийн даатгал саяын Сандаг-Очир гишүүний ярьж байгаа сэдэвтэй харьцуулбал энэ харьцангуй жижигхэн нэг чиглэлийн нэг мөр аудит л байгаа юм л даа. Солилоо гэж үзэхэд ажлын объём бол нэг их өөрчлөлт гарахгүй хэмжээний л юм байгаа юм.

Хог хаягдлын асуудал үнэхээр тулгамдсан асуудал байна.

Хүүхэд хамгааллын асуудал маш чухал аудит гэж бид судалж үзэж харсан.

Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцоо, үр нөлөө ер нь бол төрийн байгууллагуудын ажлын ачаалал болон ёс зүй, тэр ажиллах нөхцөл бололцоо эд нар гээд үүнийг бас цогцоор нь харж хийх нь зайлшгүй тулгамдсан асуудал гэж л харж байгаа юм л даа.

Зүгээр Ирээдүй өв сан дээр л нэг тийм.

Г.Тэмүүлэн: Улсын төсвийн хөрөнгөөр 32. Энэ яах вэ.

Д.Занданбат: Энэ аудитаа саяын тэр Батжаргал гишүүний хэлж байгаа аудит руу нарийвчлаад энэ юман дотор оруулчихъя гэж санаж байгаа. Улсын төсвийн хөрөнгөөс санхүүжүүлсэн геологи, судалгааны ажлын хэрэгжилт, үр дүнг бол тэр газрын тосны аудитын юм руу нь бас чиглүүлсхийгээд ингээд энэ 2-ыг базаад нийлүүлээд.

Үгүй ээ, үгүй тэр чинь хуулиар хийх аудит байхгүй юу. Үгүй ээ, үгүй энэ бүтээгдэхүүн авах гээд гүйцээж хийж байгаа шүү дээ. Энэ бүтээгдэхүүн авах уу? Тийм бүтээгдэхүүн авах үгүй ээ үгүй. Энэ чинь хуулиараа хийж байгаа баталгаажуулах аудит шүү дээ. Нөгөөдөх чинь Батжаргал гишүүний хэлээд байгаа чинь гүйцэтгэл нийцлийн аудит байхгүй юу. Тэгэхээрээ зэрэг энэ чинь 2 өөр чиглэлийн аудит. 1 нь баталгаажуулах, 1 нь нийцэл гүйцэтгэл үр дүн харах 2 бодлогоор хийгдэх аудит, хуулиар хийх аудит, 2 чинь.

Газрын тосны бүтээгдэхүүн хуваах тоо хэмжээг ерөнхийдөө баталгаажуулж байгаа хэлбэрийн аудит. Тэгээд тухайн Газрын тосны хэрэг эрхлэх газар хийчихсэн. Ашигт малтмалын газар манайд ирүүлчихсэн тайланг бид нар баталгаажуулна гэсэн үг. Одоо тэр хуулиар хийж байгаа ажил. Адилхан хайгуул олборлохтой адилхан, зарчмын хувьд адилхан.

Саяын Батжаргал гишүүний хэлж байгаа бол ерөөсөө нөөц тогтоох. Тэгээд ерөөсөө энэ бүтээгдэхүүн хуваагаад байдаг манай дээр ямар хэмжээний нөөц байгаа эд нартай холбоотой нэлээн үр дүнтэй байлгах талын аудитыг манайд хэлчихлээ гэж ойлгоод байгаа юм. Сэдвийн аудит хэлчихлээ гэж ойлгоод байгаа юм.

Г.Тэмүүлэн: Тэгвэл тэгээд бодлогоор гүйцэтгэх аудитын сэдвээс 30

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дахь ажлыг нь хасаад, нэмэлтээр саяын Сандаг-Очир гишүүний гаргасан саналыг нэмж тусгаад ингээд батлахад болох уу? Ойлголоо.

Тэгвэл ийм байдлаар сэдвийг баталъя.

Ингээд Аудитын сэдэв батлах тухай Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай.

Булгантуяа, Баделхан, Раднаасэд гишүүд. Баделхан гишүүн санал гаргачих уу, та. Баделхан гишүүнд микрофон.

Х.Баделхан: Саяын саналыг хүчингүй болгоод дахин санал хурааж өгөөч гэж хэлье.

Г.Тэмүүлэн: Ойлголоо, микрофон нь ажилласангүй.

Ингээд Баделхан гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Техник, тоног төхөөрөмжийн асуудлаас болж санал хураалт алдаатай явагдсан байна. Санал хураалт. Баделхан гишүүний саналаар өмнөх санал хураалтыг хүчингүй болгох. Гишүүд анхааралтай байгаарай, Раднаасэд гишүүн.

60 хувиар дэмжигдлээ.

Баделхан гишүүний санал дэмжигдсэн учраас саяын санал хураалтыг дахиж явуулъя.

Аудитын сэдэв батлах тухай Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 10 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжин, 60 хувиар дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдэж байна.

Байнгын хорооны гишүүд болоод ажлын хэсэгт баярлалаа.

17.51 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ УУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ